

Сонирхол татах сонгуулийн ирц

Сонгууль гэдэг бол нэг талаас сонгох эрх боловч нөгөө талаас сонгохгүй байх эрх юм. > 2

Lingua franca-2

XXI зуун Хятадын зуун болно гэх таамгийг баруунд бүтээж буй метатехнологи өөрчлөв. > 4

Онлайн сурталчилгааны маргаантай ирээдүй

Adblock-ийн хэрэглээ 2015 он гэхэд нийт интернэт хэрэглэгчийн 48 хувьд хүрэв. > 6



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.05.23, МЯГМАР ~ №096 (642)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгчийн сонгуульд нам 6.9, нэр дэвшигч 3.9 тэрбум төгрөг зарцуулна.

ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн маргаашийн хурлаар Монголын асуудлыг хэлэлцэнэ.

Японд төмс экспортолж, Хятадтай хамтарсан лаборатори байгуулна гэв.

Гадаадад байгаа 7374 иргэн Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхөөр бүртгүүлжээ.

Дэлхийн зүүн төвийн үзэл баримтлалтай намууд Улаанбаатарт чуулна.

ЭДИЙН ЗАСАГ

"Оюутолгой"-н орлого 5.7 хувиар нэмэгдэж, 237.5 сая ам.доллар болов.

Хөрөнгийн биржийн индекс энэ өдөр 845.01 нэгж болж, 0.4 хувиар өслөө.

Монголбанкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 1.1 их наяд төгрөгтэй тэнцлээ.

Улсын хэмжээнд банк бус сан- хүүгийн нийт 529 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Япон улсын экспорт дөрөвдүгээр сард жилийн өмнөхөөс 7.5 хувиар өсөв.

НИЙГЭМ

Сөүлийн гудамжийг авто- машингүй "Шөнийн гэрэлт гудамж" болгон тохижуулна.

Арьс ширний гэгдэх 80 айлын орон сууцыг дахин барилгажуулахаар болов.

Улсын хэмжээнд 360 га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн байсныг 430 га болгожээ.

Гэр хорооллын айл өрхийн нохойг бүртгэж, үржил хязгаарлах ажил 66 хувьтай байна.

УДБЭТ-ын 54 дэх улирлын тоглолт "Дэггүй Лиз" хэмээх шинэ уран бүтээлээр эхэлнэ.

ДЭЛХИЙ

Трамп Израил, Палестиныг хэлэлцээрийн ширээний ард суулгахаар төлөвлөв.

БНХАУ тагнуул хийсэн хэргээр Японы зургаан иргэнийг баривчиллаа.

Туркийн Ерөнхийлөгч эрх баригч намын тэргүүнээр сонгогдов.

Европын холбоо Их Британид тэрбум фунт стерлинг төлөх ёстой гэж Тереза Мэй үзэж байна.

SpaceX компани сансарт чандар оршуулах үйлчилгээ санаачлав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.05.23



24° | 5°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭВГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС ҮНШИНЭ ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Зууны төслийн хаялга



Дэд бүтцээр дэлхийг хэрэх "Нэг зам, нэг бүс"-д Монгол Улс илүү ажил хэрэгч хандахгүй бол олон улсыг хошууруулж буй Хятадын санаачилга биднийг хүлээхгүй нь. ▶3

ЗГМ: СЭДЭВ

Дэмжлэг дутсан гарааны бизнес

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Инновацийн тухай хуулийг 2012 онд баталснаар гарааны бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдэж, шинэ бизнес эрхлэх хүсэлтэй олон хүнд итгэл найдвар төрсөн. Энэ хуулийн хүрээнд төрөөс гарааны бизнес эрхлэгчдэд гурван жилийн хугацаанд татварын болон гаалийн хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан нь энтрепренерүүдийн хувьд шинэ бизнесээ бойжуулахад авах алтан боломж байлаа.

Гэхдээ төрийн зүгээс хэн хүссэнийг "гарааны" хэмээн

тодотгож, хавтгайруулахыг хүссэнгүй. Асуудал иймээс Засгийн газрын тогтоол гаргаж, зөвхөн эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулсан компанийг гарааны бизнес эрхлэгч хэмээн батламжлахаар холбогдох журмаар гаргасан. Өдгөө их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны 31 компани үйл ажиллагаа явуулж байна. Тодруулбал, 2015 онд 12, 2016 онд 19 компани гарааны бизнес эрхлэх зөвшөөрөл авчээ. Төрөөс инновацийг хөгжүүлэх тал дээр дорвитой анхаарч эхэлсэн нь энэ.

▶5



Дордсоор буй Саудын Араб-Ираны харилцаа

Ричард Хаас

Эрхэм дээдсийн Засгийн газар Суэцийн сувгаас дорно зүгт Британийн гүйцэтгэж ирсэн уламжлалт үүргээ биелүүлж дөнгөхөө больсноо ухамсарласнаас хойш 50 орчим жил өнгөрч байна. Тухайн үед Зүүн өмнөд Азийн бүс нутагт хүнд ачаа үүрчихээд байсан АНУ-ын засаг захиргааны хувьд энэ нь бас л дарамт байлаа. АНУ-ын холбоотнууд Зөвлөлтийн нөлөөг хязгаарлах, оршин буй бүс нутгийнхаа аюулгүй байдлыг хангахад жинтэй үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн онолыг Ерөнхийлөгч Ричард Никсон, түүний үндэсний аюулгүй байдлын зөвлөх Хэнри Киссинжер хоёр чухам тэр үед дэвшүүлсэн юм.

Арабын хойг, булангийн бүс нутагт уг үүргийг Саудын Араб,

Иранаар гүйцэтгүүлэхээр Вашингтон чармайсан. Энэ хоёр улс ч газрын тосоо АНУ-д нийлүүлснийхээ төлөө авдаг ам.доллараар эргүүлээд цэргийн зэвсэг техник худалдан авч, хүлээсэн үүргээ биелүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн байжээ. Гэвч хувьсгалаар шахын дэглэм нурж, АНУ-д дайсагнагч Исламын Бүгд Найрамдах Улс 1979 онд гарч ирснээр "хос багана"-ын эрин үе төгсгөв.

Саудын Араб, Иран нь одоо ч тус бүс нутгийн хамгийн хүчирхэг улс хэвээр. Гэхдээ ширүүн өрсөлдөгч болж хувирсан хоёр улсын хоорондох үгэн дайн болон аль алиных нь түлхээстэй мөргөлдөөн тэмцэл бүр ч сүйтгэгч үр дагавартай болон хувирч магадгүй боллоо.

▶9

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгө оруулалтыг хялбар босгох гарц

Б.Мөнх
ЗГМ

Хувьцаат компаниуд нэг болон түүнээс дээш тооны хөрөнгийн бирж дээр үнэт цаасаа бүртгүүлснээр шаардлагатай хөрөнгө оруулалтыг хурдан хугацаанд татаж чаддаг. Энэ нь тухайн компанийн хувьд олон улсад танигдах бас нэг боломж нь болдог юм. Ийм учраас Монголын хөрөнгийн бирж давхар бүртгэлийн системийг

эхлүүлэхээр төлөвлөж байна. Одоогийн байдлаар гадаадын таван хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 30 гаруй монгол компани байгаа аж. Эдгээр компаниас зарим нь Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх хүсэлтээ ирүүлж байсан. Тиймээс ойрын хугацаанд давхар бүртгэлийн системийг нутагшуулах нь.

Хөрөнгийн биржийн зүгээс давхар бүртгэлийн системийг эхлүүлэхээр Хонконг болон Торонтогийн хөрөнгийн бирж-

тэй хамтран ажиллах талаар ярьж эхэлсэн. Тухайлбал, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 11 компани байдаг. Монголын хөрөнгийн бирж Торонтогийн биржтэй хамтрах тохиолдолд тус биржид бүртгэлтэй компаниуд манай улсын хөрөнгийн зах зээлд давхар бүртгэлтэй болох юм.

▶11

Ц.Төмөрхуяг: "Cinema Awards" уран бүтээлчдийн хүлээлтийг хэд дахин давж чадлаа

Монголын кино урлагийн нэрт төлөөлөгч, Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн соёрхолт Цагааны Цэгмидийн хүү, соёлын тэргүүний ажилтан Цэгмидийн Төмөрхуяг "Cinema Awards" Монголын кино урлагийн дээд шагнал гардуулах ёслолын "Шилдэг эрэгтэй туслах дүр" шагналын эзэн болсон билээ.



дүрийн шагналыг хүртсэндээ тун баяртай байна. Улаан хивсний ёслолын дараа хойшуулшгүй кино зураг авалттай байсан тул өөрийн биеэр шагналаа авч чадаагүй харамсалтай зүйл болсон.

-Монголын киночдоо дэмжсэн ийм хэмжээний кино наадам болохын ач холбогдлыг та хэрхэн харж, дүгнэж байна вэ?

-Анх удаа зохион байгуулагдаж байгаа, мөн кино театрын уран бүтээлчид өөрсдөө зохион

байгуулсан учраас илүү академик тал руугаа хандсан, чанартай үйл ажиллагаа боллоо гэж бодож байна. Өмнө нь Монголд зохион байгуулагдаж байгаагүй шинэлэг арга хэмжээ болно гэсэн хүлээлттэй байсан. Хүлээлтэнд ч хүрч чадлаа. Миний хувьд киноны салбараас шагнал авч үзээгүй байсан. Анхны шагнал байлаа. Арга хэмжээний хувьд нүсэр зохион байгуулалттай, сайхан болж өнгөрсөн.

▶6

MSE ALL

845.01
0.4%

АЛТ

1256.70
0.09%

ЗЭС

5682
1.8%

10-ЧИНГИС БОНД

96.830
0.17%

5-ЧИНГИС БОНД

100.02
0.04%

АМ.ДОЛЛАР

2417.20

ЮАНЬ

350.75

РУБЛЬ

42.75

Нийтлэлчийн булан

**БНХАУ-ын дарга
Ши Жиньпин
уг санаачилгыг
Зууны төсөл
хэмээн
тодорхойлов**

Г.Байгал
@baigalZGM

Их гүрэн агуу амбийцтай болсныг та анзаарав уу. Урд хөрш дэлхийг өөрчлөхөөр зориг шулуудчихаж. Гэхдээ “бид өөрчилнө”, “цэнхэр гарагийг манлайлна” хэмээн цээжээ дэлдсэнгүй. Харин үг хийгээд үйлдлээрээ энэ санаагаа ил болгосоор.

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-д олон улсын хамтын ажиллагааны “Нэг зам, нэг бүс” чуулган болж, өндөрлөв. Хятадын нийслэл Бээжинд болсон уг чуулганд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешээс гадна ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Туркийн Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоан тэргүүтэй дэлхийн 30 орчим улсын төрийн тэргүүн, цэнхэр гарагийн 130 орны төлөөлөгч, олон улсын 70 гаруй байгууллагын төлөөлөл оролцжээ. Урд хөршийн саарал хотыг зорьсон оролцогчдын тооноос Бээжингийн зүтгүүлж буй “Нэг зам, нэг бүс” санаачилгын нэр хүнд, сүр хүчийг харж болохоор байсныг олон улсын ажиглагчид онцолж байна. Харин чуулганд оролцогчдын үг уг санаачилгын үр нөлөөг дэлхийн тавцанд тунхагласныг шинжээчид тодотгож байгаа юм.

ӨСӨЛТИЙН ХҮЧ

Энэ бол Зууны төсөл. БНХАУ-ын дарга Ши Жиньпин уг санаачилгыг ийн тодорхойлов. Зүгээр ч нэг биш, дэлхийн шинэ итгэл найдвар хэмээн тэрбээр дүгнэж байна. Энэ сарын 14-15-нд болсон чуулганы үеэр урд хөршийн дарга “Уг санаачилга нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн шинэ хүчийг бий болгож, хөгжлийн цоо шинэ хэлбэрийг цогцлоож, эдийн засгийн даяарчлалыг тогтворжуулна. Зөвхөн Ази, Европ, Африкаар хязгаарлагдахгүй, дэлхийн бүх улс оронд нээлттэй” хэмээн мэдэгдсэн юм. Хятадын төрийн тэргүүний үг хэтрүүлж бишийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш ч батлав. Тэрбээр урд хөршийн энэ санаачилгын үр дүнг үлэмж хэмжээгээр сайшаажээ. Өөрөөр хэлбэл, олон улсын удирдагчдын мэдэгдлээс нэгэн цагт



“Нэг зам, нэг бүс” санаачилга өдгөө дэлхийн хөгжлийн зүтгүүр, өсөлтийн найдвар болчихоод байгааг харж болно.

Зууны төслийн хаялга

уриа, лоозон төдий байсан “Нэг зам, нэг бүс” санаачилга өдгөө оролцжээ. Урд хөршийн саарал хотыг зорьсон оролцогчдын тооноос Бээжингийн зүтгүүлж буй “Нэг зам, нэг бүс” санаачилгын нэр хүнд, сүр хүчийг харж болохоор байсныг олон улсын ажиглагчид онцолж байна. Харин чуулганд оролцогчдын үг уг санаачилгын үр нөлөөг дэлхийн тавцанд тунхагласныг шинжээчид тодотгож байгаа юм.

Ингэхэд энэ төсөл анхнаасаа ийм хэмжээний өндөр ач холбогдолтой байсан бил үү. Эргэн санахад, 2013 оны есдүгээр сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Төв Азийн орнуудад айлчлах үеэрээ Торгоны замыг сэргээх санаачилга танилцуулсан. Энэ нь тэртээ олон зууны өмнө Ази, Европыг хэлхэж байсан Торгоны замыг шинэ зуунд эргэн авчрахад чиглэж байв. Тиймээс Азийн хэдхэн орныг хамарч байсан юм.

Гэтэл өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд л санаачилга “зүс”-ээ ч, зорилгоо ч тэр өөрчилсөөр өдгөө дэлхийг хэрсэн худалдааны дэг жаяг болон хувираад байна. Уг төслийг анх танилцуулж байхад АНУ, Канад, Англи, Герман, Франц, Япон зэрэг орнууд эсэргүүцэж, урд хөршийн зүг ууртай харц чулуудаж байсан. Гэтэл өдгөө төлөөлөгчдөө илгээн, дэмжихээ илэрхийлж байх жишээтэй.

ӨНГӨРСӨН ДӨРВӨН ЖИЛД ЮУ БҮТЭЭВ

Яагаад улс орнуудын санаа бодол ийн өөрчлөгдөв. Ер нь Хятад эдийн засгийн шинэ хөзрөө дэлгэсэнээс хойших өнгөрсөн дөрвөн жилд юу бүтээснийг эргэн санае. Одоогоор дэлхийн 65 улс

уг санаачилгад нэгдсэн. Цаашид энэ замаар замнах улс орнуудын цуваа ч тасрахгүй байна. Үүнээс гадна Дэлхийн банк, ОУВС тэргүүтэй байгууллагууд түншлэхээ мэдэгдээд байгаа ч тэднийг хүлээлгүй Бээжингийн холбоотнууд санхүүгийн хэд хэдэн тоглогчийг өнгөрсөн жилүүдэд төрүүлж амжсан юм. Бидний сайн мэдэх Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт банк бол үүний нэг жишээ. Үүнээс гадна Торгоны замын сан, БРИКС-ийн Шинэ хөгжлийн банк гээд Хятадын амбийцийг “амилуулах” олон байгууллага бий болсон. Үүгээр зогсохгүй илүү ч өргөжүүлэхээ амлаад байна. Тодруулбал, Торгоны замын сангийн хөрөнгийг 100 тэрбум юаниар зузаатгаж, урд хөршийн Хөгжлийн банк, Экспорт, импортын банкаас банк санхүүгийн хамтын ажиллагаанд нийлүүлэх аж. Үүнээс гадна ирэх таван жилд Торгоны зам дагуух орнуудаас хоёр их наяд юанийн импорт хийнэ. Өмнөд хөршийн дарга Ши Жиньпиний мэдэгдэж буйгаар энэ санаачилгын хүрээнд 800-900 тэрбум юанийн мөнгө дэлхийн “судас”аар урсахаар байгаа аж.

Тиймээс өмнөд хөршийн төрийн тэргүүн өөрийн автортай энэ санаачилгаа Зууны төсөл хэмээн ам бардам хэлж байна.

Товчхондоо “Нэг зам, нэг бүс” бол ийм аварга бүтээн байгуулалт юм. Тийм ч учраас хэдхэн жилийн өмнө үл хайхарч байсан улс орнууд өдгөө итгэл тээсэн нүдээр урд хөршийг ширтэж байна.

ХУДАЛДААГ ТЭСЛЭХ ШИНЭ “ПУУЖИН”

Төгвөл дэлхийн худалдаанд тэсрэлт авчирч мэдэх ийм “пуужин” Монголын дэргэдээс хөөрөх гэж байхад хэдэн зууны турш хуурай замыг хэлхсэн нүүдэлчид хоосон үлдэх гэж байгаа юм биш биз.

Уг санаачилгыг удирдаж буй Хятадын хөгжил, шинэтгэлийн хорооны мэдээлсээр “Нэг зам, нэг бүс”-ийг эдийн засгийн зургаан коридор зангидаж байгаа. Энэ зургаан коридорын нэг нь Монголыг дайрч буй юм. Евразийг холбосон хуурай газрын хамгийн дөт зам Хятад-Монгол-ОХУ-ыг дамжин өнгөрөхөөр байгаа нь олон жилийн өмнөөс тодорхой болсон. Тиймээс ч зам дагасан мөнгөний урсгалаас хүртэхийн тулд монголчууд сүүлийн жилүүдэд энэ чиглэлд идэвхтэй байгаа. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт Монгол, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нар өнгөрсөн онд Узбекистаны нийслэл Ташкент хотноо гарын үсэг зурсан. Энэ коридорын зураглал, төлөвлөгөө нь хэдийнэ бэлэн болсон юм.

Гэвч гэрээг үзэглэснээс хойш олон сар өнгөрөөд байгаа ч дэлгээд харуулчих томоохон бүтээн байгуулалтгүй өдий хүрч байна. Олон улсын авто замын туршилтын тээврийг өнгөрсөн онд хийснээс өөр ахиц үнэндээ гарсангүй. Санхүүжилтээ хүлээсэн хэдэн төсөл нь салбарын яамны шүүгээнд “хэвтсээр”. Холбогдох албаныхан дэд бүтцийн өнөөх төслүүдэд санхүүжилт татахаар хүсэлт тавьсан хэмээн ам тагласаар өнөөдрийг хүрлээ. Гэтэл биднийг мөнгө хүлээн, толгойгоо гашилгах зуур ОХУ зорилгоо тодорхойлж, төлөвлөгөөгөө гаргачихаад, ажилдаа хэдийнэ ханцуй шамлан оржээ.

Эдийн засгийн коридорын хүрээнд хойд хөршид дэд бүтцийн төслүүд “буцалж” байна. ОХУ-ын fiss.ru цахим хуудсанд дурдсанаар зам тээврийн томоохон төслүүдийг эхлүүлээд буй аж. Тодруулбал, М54 дүгээр замыг шинэчилж, Тува, Хандгайт, Боршоо цаашлаад Монголыг дайрч Хятадын хойд нутгийг чиглэсэн зам тавих ажлыг эхлүүлжээ. Бас хойд, өмнөд хөршийг холбосон Харбин хотын олон улсын “Тайпин” нисэх буудлыг өргөтгөж, Зүүн хойд Азийн агаарын тээврийн зангилаа болгохоор зэхэж байна. Эдгээрт нийт 350 тэрбум рубль зарцуулж байгаа бөгөөд багагүй хэсгийг нь Хятадын санхүүжилт

бүрдүүлж байгаа аж.

Бас Зууны төсөл дагасан санхүүжилт Төв Азиар урсаж байна. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк л гэхэд хэдийнэ 1.7 тэрбум ам.долларын зээл олгоод буй. Гэвч шинэ банк биднийг тойруулан мөнгөө “нигсгээр” байгаа юм. Уг нь Монгол Улс “Нэг зам, нэг бүс”-ийн тоглогч гэдэг утгаар манай дэд бүтцийн төслүүдийг сонирхох хөрөнгө оруулагчдын хандлага сул биш. Гэхдээ Монголын гэх тодотголтой төслүүдэд мөнгөө өгчих зоригтой хөрөнгө оруулагч одоогоор ховор байна.

» Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд энэ санаачилга “зүс”-ээ ч, зорилгоо ч тэр өөрчилсөөр өдгөө дэлхийг хэрсэн худалдааны дэг жаяг болон хувираад байна.

» Хятадын хөгжил, шинэтгэлийн хорооны мэдээлсээр “Нэг зам, нэг бүс”-ийг эдийн засгийн зургаан коридор зангидаж байгаа.

» Эдийн засгийн коридорын хүрээнд хойд хөршид дэд бүтцийн төслүүд “буцалж” байна.

» Бид илүү ажил хэрэгч, үр дүнтэй ажиллахгүй бол дэлхийг хошууруулж буй Хятадын санаачилга Монголыг хүлээхгүй нь.

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



Монгол бол Евразийн хамгийн дөт коридор. Үүнийг баталсан ганцхан баримт дурдахад, Монголын транзит тээвэр Европ-Хятадыг холбосон Манжуурын замаас бүхэл бүтэн 1135 км-ээр богино. Бас Казахстаны замаас 1600 км-ээр дөт гээд бол.

Ийм л газар зүй, геополитикийн хосгүй байршлыг бид эзлэн сууж байна. Хятадын зүтгүүлж буй энэ санаачилга алсаа манай эдийн засагт зүтгүүр болох нь тодорхой. Тиймээс энэ чиглэлд илүү хүч, анхаарал тавих зайлшгүй шаардлага тулгараад байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Бээжинд болсон чуулга уулзалтын үеэр ч манай дэвшүүлж буй “Хөгжлийн зам” хөтөлбөрийг БНХАУ-ын санаачилгатай уялдуулан хэрэгжүүлэхээр тохиролцсон. Бас энэ чиглэлийн хэд хэдэн хэлэлцээг ч хийгээд амжжээ.

Гэхдээ л бид илүү ажил хэрэгч, үр дүнтэй ажиллахгүй бол дэлхийг хошууруулж буй Хятадын санаачилга Монголыг хүлээхгүй нь. Цэнхэр гарагийг хэлхсэн эдийн засгийн хөгжил хөдөлгөөн дунд бид торойн үлдэх вий. [ЗГМ]

Судлаачийн үг

Lingua franca-2

Олхонуд Баярхүү
судлаач проф.

Геополитикийн чухал зэвсэг нь
хэл болох тухай

Британи, Америк хоёр 200 жилийн турш колоничлол явуулж, худалдаа, аж үйлдвэрлэл, шинжлэх ухаан, санхүүгийн асар их эрх мэдэлтэй байснаараа дэлхий дахинд боловсрол, соёл, засаглал, худалдаа, технологийн шинэ нөхцөлийг хуульчлан өвлүүлжээ. Эдүгээ англи хэлийг төрөлх хэлээ гэж үздэг 500 орчим сая хүн, хоёр дахь хэлээ гэж үздэг 1.5 тэрбум хүн ард буй тухай Wikipedia-д бичжээ.

Британи, Францын аль алин нь колониуддаа хэл, соёлоо тулгасан. Колони ихэнх орнууд нь тусгаар тогтносныхоо дараа эзэн улсынхаа хэлээс татгалзан төрөлх хэлээ сэргээж, гаднын соёлыг шахах бодлого их бага хэмжээгээр явуулсан боловч тууштай үр дүнд хүрээгүйн жишээ бол төрийн хэл нь англи байгаа Сингапур, Хонконг хоёр байна. Зөвлөлт Холбоот Улс ид цэцэглэн мандаж байх үед орос хэл нь Прагаас Улаанбаатар, Ханой хүртэл lingua franca болж байлаа. Харин СССР гэх эзэнт гүрэн нурж унасан тэр аясаар орос хэлийг төрийн хоёрдугаар хэл гэх нь Дорнод Европ, Монголд бүр байхгүй болсон бол одоо Украин, Гүрж орос хэлнээс бүр татгалзаж байх шиг.

Манай Монголд орос хэл мөн ч өндөр авсан даа. Орос хэлний багшийн дээд сургууль, төрийн албанд удирдах тушаалд очиж буй бүх хүн орос хэлээр шалгалт өгдөг байсан гээд жишээ маш их бий. Орос хэлний багш гэж хосгүй гоё мэргэжил хүртэл манайд байлаа. Дэлхийд геополитикийн эрх мэдэл, нөлөө нь нэмэгдэхийн хэрээр тухайн хэл түгж, тархдаг жишээ бол социализмын үеийн орос хэл гарцаагүй мөн л дөө.

Дэлхийд эрх мэдлээ тогтоосон тэр гүрний төрөлх хэл нь дэлхийн түгээмэл хэл болмогч тэр ард түмэн ихээхэн бардам болж, бусад ард түмэн тэдний хэлийг сурахаар хошуурдаг нь жам ёсны үзэгдэл юм. Өнөөгийн АНУ ба түүний англи хэлийг жишээлж

болж байна. АНУ дэлхийд ноёрхоод байгаад дөрвөн хүчин зүйлээр нөхцөлдөж байна гэж үздэг. Энд мэдээж, цэрэг-стратегийн хүч нөөц нь орно. Хоёрдугаарт эдийн засгийн асар их хүч нөөц нь орно. Тэнд дэлхийн ДНБ-ий 30 орчим хувь нь байна. Үүний дараа шинжлэх ухаан-технологийн асах их хүч нөөц нь орно. Соёлын асар их нөлөөлөл түүнийг тээгч англи хэл нь мөн орно. Соёл гэдгээр зөвхөн Холливудын энэ их кинонууд, энэ их дуу хөгжим, бохь, жийнс, кола тэр чигтээ зэвсэг болон дэлхийгээр түгэн тархаж байгааг хэлж байна.

Берлиний хана нуран унасны дараа германчуудын үндэсний сэтгэлгээ сэргэж, англи хэлээр чөлөөтэй ярьдаг байсан нэгэн нь олон улсын хурал дээр тэд германаар ярихыг зорьж байв. Японы эдийн засгийн хүчин чадал япон бус улс түмэнд япон хэл сурахыг тулгаж, Хятадын эдийн засгийн эрчтэй хөгжил хятад хэлийг мөн тийм хэмжээд гаргаж иржээ. Үүнийг Монгол дахь хятад, япон хэлний сургалт, тархалтаар нотолж болно. Энэ чинь хэл сурах сургалт үйл явц биш, бид чинь гадаад хэлний тулгалтын өмнө хүчин мөхөсдөж буйг хэлж байна.

Эдүгээ Зүүн өмнөд Ази дахь хятад цагаачдаар дамжин тус бүс нутагт олон улсын бизнес хятад хэлээр англи хэлтэй зэрэгцэн явагдаж байна. Өрнийнхний эрх мэдэл, хүч чадал суларч, бусад иргэншилд байраа тавихын хэрээр бусад нийгэмд англи болон өрнийн бусад хэлийг шахах, өөрчлөн хэрэглэх явдал харагдах болж байна. Холын ирээдүйд Хятад нь өрнийнхний оронд дэлхийд ноёлох иргэншил болж гарч ирвэл англи хэл lingua franca байхаа больж, харин хятадын мандарин хэл түүнийг орлоно гэх таамаг байдаг. Гэвч энэ нь юу л бол.

XXI зуун Хятадын зуун болно, Азийн зуун болно гэх таамгийг баруунд яг одоо бүтээж буй метатехнологи өөрчилчихлөө. Энд метатехнологиос зөвхөн web-технологийг нь салгаад аваад үз л дээ. Microsoft, Apple, түүний iphone-ууд, ipad, мөн Facebook, Twitter, LinkedIn, WiFi, youtube-ийг хятад хүний оюун тархи яагаад бүтээж чаддаггүй юм бэ гэх энгийн асуулт тавиад, хариулт хайгаад үз. Microsoft, Apple, түүний iphone-ууд, ipad, мөн Facebook, Twitter, LinkedIn, WiFi, youtube чинь бүгд англи хэлээр бүтээгдэж, англи хэлээр түгэн тархаж байгаа тул англи хэлийг яалт ч үгүй дэлхийн гол хэл болго гээд тулгачихаж байгаа хэрэг.

Та нар компьютерээ өглөө нээдэг дээ. Start windows гэсэн бичиг гараад ирдэг дээ. Цонхоо нээ гэсэн үг шүү дээ. Яг үнэндээ бол “Нүдээ нээ, мэлмийгээ нээ, цаана чинь бид байна. АНУ байна” гэсэн үг л дээ. Дэлхийд эрх мэдлээ тогтоосон тэр гүрний төрөлх хэл нь дэлхийн түгээмэл хэл болж буйн гашуун жишээ бол энэ их компьютерын бүчилт биш гэж үү. Өөр нэг жишээ. Wikipedia гэх лавлахыг аваад үз. Ердөө л жирийн хэрэглээ шүү дээ. Мэдээлэл авья гээд нэг сэдэв сонго. Англиар бол нүүр дүүрэн, талбай нь чигжүү мэдээлэл гарч ирэх бол орос хэлээр түүний тал, монгол хэлээр хоёр абзац

хүрэхтэй, үгүйтэй текст гарч ирдэг. Бараг хүн үздэггүй учраас тэр шүү дээ.

Колони асан орнууд тусгаар тогтнохын хэрээр уугуул төрөлх хэлээ дээдлэн, эзэн улсын хэлийг шахах нь зүй ёсны боловч хөгжлөө дагаад англи хэлийг тийм болгочихож арай чадахгүй өдий хүрчээ. Үндэсний элитүүд нь үндэсний дүр төрх онцлогоо сэргээж, тэгснээрээ өрнийнхний хараат байдлаас салах зорилго тавивч хэлэн дээр тэгж чадахгүй, эсвэл хүсэхгүй байх шиг. Африкт англи, франц, португал хэл л ноёлж байна. Хойд Африкт бол араб хэл.

Монголд нөмрөөд ороод ирсэн мэт надад санагдах

Үндэсний лут элитүүд тусгаар тогтносныхоо дараа энгийн харц ардаасаа товойж ялгарах хэрэгтэй болдог, үүнд нь англи, франц болон бусад өрнийн хэл эргээд үйлчилдэг. Ингэснээрээ өрнийн бус улс орны дээд элит хэсэг харц ардтайгаа харилцахаас илүүтэй өрнийнхөнтэй үг хэлээ ололцох болжээ. Энэ нь XVII, XVIII зууныг санагдуулах бөгөөд тэр үед барууны ноёд, дээдээс франц хэлээр ярьдаг, харин өөрийн унаган хэлээ мэддэггүй байв. Энэ гайт үзэгдэл өнөөгийн Монголд нөмрөөд ороод ирсэн мэт надад санагдах юм. Бритиш сургууль, америк сургууль, олон улсын сургууль, Орчлон, Хобби гээд дээд элитийн бяцхан үрсийн тансаглалын газар буй болж, англи хэлийг орой дээрээ залчихаад явж байна. Социализмын үед энгийн харц ардаасаа товойж ялгарах гол хэрэгсэл нь орос хэл, орос дунд сургууль, орос дэлгүүр гээд жагсаж байсантай эгээ л адил үзэгдэл юм.

Өрнийн бус ертөнцөд өөр хоорондоо зөрчилтэй үндсэн хоёр хандлага яг одоо бий болоод байна. Нэг талаас англи хэлийг их, дээд сургууль, дунд сургуульд өргөн зааж буй. Монголоор жишээлсэн ч болно. Капитал, зах зээлийн төлөө глобал өрсөлдөөнд англи хэл гол хөтөч болж байгаа учраас би огтоос буруутгахгүй. Гэтэл нөгөө талаас нийгэм, улс төрийн дарамт нэмэгдэхийн хэрээр уугуул төрөлх хэлээ илүүтэй гарган тавьж, Хойд Африкт франц хэлийг арабаар сольж, Пакистанд англи хэлний оронд урду хэлийг төр засаг, боловсролд нэвтрүүлж, Энэтхэгт үндэсний хэл дээрх мэдээ мэдээлэл англи хэл дээрх нэвтрүүлгээсээ давж гарчихсан сонин тохиолдол 1990 оны дунд үеэс ажиглагдсан. Харин манайд бол тэгж туйлшраагүй.

Зөвлөлтийн эзэнт гүрэн нурж, “Хүйтэн дайн” шувтарсны дараа дарамтлагдан мартчихаад байсан үндэснийхээ төрөлх хэлийг сэргээж, шинэчлэх хандлага СССР-ийн гишүүн асан шинэ БНУ-уудад эрчтэй өрсөнжээ. Хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан орнууд уламжлалт хэл, соёлоо сэргээх замаар шинэ амьдралаа бий болгож байна. Эдүгээ эстон, латви, литва, украин, гүрж,

армен, түрэг, азербайжан, молдова хэлнүүд тусгаар тогтносон улсынх нь үндэсний хэл болж бүрэн чадсан. Лалын БНУ-уудад нь мөн ийм хандлага газар авч, Азербайжан, Кыргызстан, Туркменистан, Узбекистанд орос кирилл бичгийг халж, угсаа нэгт түрэг бичигт шилжсэн бол перс хэлээр ярьдаг Тажикистанд араб бичгийг авчээ. Казах хэл хараахан тэгж чадсангүй. Орос хэлээр төрийн албан хэргээ залгуулсаар байна.

Сербияд өөрийн хэлээ серби-хорват гэхээ больж, зөвхөн серби гэж нэрлэн, өрнийн католик “дайсны” бичиг үсгийг угсаа нэгт Оросын кирилл бичгээр сольж, харин Боснид чухамдаа 450 жил Оттоманы гүрний Балкан дахь ноёрхлын ул мөр болсон түрэг, араб гаралтай үг хэллэгийг дуртайяа шүүрэн авч сэргээн хэрэглэсэн жишээ байна. Хэтдээ тэд Европын холбоог бараадвал англи хэл рүү л явж

таарна. Ерөөсөө Британи нь Европын холбооноос гарах гэж байдаг, гэтэл Европын холбооны гол хэл нь англи хэл хэвээрээ үлддэг, үүнийг тайлбарлах арга байна уу.

Ер нь монгол хэл гээд яс үзээд байдаг багш, эрдэмтдэдээ хэлэх нэгэн сануулга байна. Хэл гэдгийг төр нь тодорхойлж, хэл бичгийн хэдэн эрдэмтэд мэдэж шийддэг байсан үе нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдсөн. Монголын ард түмний олонх нь ямар ажил үйлс эрхэлж байна, тэдний хэл яриа л монгол хэлний хөтөч болж байна. Монголчууд нүүдэлчид байснаа худалдаачид болсон. Худалдаачин ард түмэн гээд нэрлэхчхэд хилсдүүлэлт болохгүй. Энэ их зах зээл, дэлгүүр хоршоо, худалдаачин ба худалдан авагч гээд бид бүгдийн монгол хэлний эрдэмтэн багш дөрвөн улирал, өвөл зун, цаг наргүй, амралтын өдөргүй өсөн дэвжиж, хөгжин буй цорын ганц

салбар бол худалдаа л байна. Үүнийг дагаад худалдааны монгол хэл төлөвшиж байгаа бус уу. Худалдаачдад зориулсан урлаг, уран сайхан, сонин, хэвлэл, зар, сурталчилгаа монгол хэлний хандлагыг тодорхойлж байна. Нөгөө талаасаа мэдээллийн эринд эргэлтгүй цохиулсан монголын залуу үе интернэтийн өөр нэг хэлтэй болж авлаа. Интернэт, гар утас гэж монгол хэл бичгийн багш эрдэмтдээс илүү хүчтэй зэвсэг орж ирээд ноёлчихоод байна. Иймд англи хэлийг бид өнөөдөр биш юм аа гэхэд, 2020-иод оноос төрийн хоёр дахь, 2030 онд нэгдүгээр хэлээ болгочихсон цохиж явах юм биш байгаа.

Миний энд бичсэнийг эх хэлээ хамгаалъя гэх уриатай, гадаад хэл үзүүлэхгүй гэсэн лоозонтой монгол хэлний эрдэмтэн багш нар маань тогтож, тэвчээр зааж, намайгаа харааж зүхэхгүй шиг уншаарай даа!

АМЖИЛТАД ХЯЗГААР ҮГҮЙ

ХАСЛИНДА АМИНТАЙ ХАМТ

Азийн бизнесийн шилдгүүдтэй уулзуулдаг “Амжилтад хязгаар үгүй” нэвтрүүлгийн энэ удаагийн дугаараар бид түрээслэх байр олоход нь тулгарсан хүндрэлээ олон сая ам.долларын бизнес болгож чадсан Стив Мэлуиштэй уулзах болно. Зүүн Өмнөд Азийн үл хөдлөх хөрөнгийн салбарын талаар ямар ч ойлголтгүйгээр бизнесээ эхлүүлж байсан түүний компани өдгөө зах зээлд ноёлж байна. Сар бүр 14 сая хүн тогтмол ашигладаг Property Guru одоо бүсдээ толгой цохисон үл хөдлөх хөрөнгийн вебсайт болоод байна.

Лхагва гараг /2017.05.24/

20:30

11:30 Пүрэв гараг

11:00 Бямба гараг

18:30 Ням гараг

Bloomberg TV Mongolia

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэсний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл-энтэртайментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co

Дугаарын удирдагч
Р.Оюунцэцэг

ЗГМ: Сэдэв

Дэмжлэг дутсан гарааны бизнес

Ямартай ч монгол эрдэмтдийн мэдлэг шингэсэн патентыг баялаг болгох 31 компани үйл ажиллагаагаа эхлээд хоёр жил өнгөрлөө. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ямар үр дүн гарсан бэ гэдэг нь хэн бүхэнд сонин. Тиймээс гарааны бизнес эрхлэгчидтэй холбогдож, бизнесийн орчин ямар байгаа талаар тодруулсан юм. Гэтэл асуудал өөрөөр эргэснийг та доорх байр сууринаас унших биз ээ.

Гарааны бизнес болгон амжилттай хэрэгждэггүй. Олон улсын туршлага ч бий. Тухайн бизнес хаана очиж цэцэглэж, хаана очиж хад мөргөх нь зах зээлийн хуулиараа шийдэгдэнэ. Гэхдээ гарааны гэсэн тодотгол зүүж байгаа нөхцөлд төрөөс ямар нэг дэмжлэг зайлшгүй үзүүлэх ёстой гэдгийг бизнес эрхлэгчид хэлж байна. Учир нь өнөөгийн нөхцөлд гарааны компаниуд банкнаас зээл авч, бизнесээ өргөжүүлэх боломжгүй байдаг аж. Төрийн өмч дээр тулгуурлан байгуулагдсан учраас зээл авах боломжгүй байдаг юм байна. Мөн шинээр гарч ирж байгаа бизнес учир үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ таниулах, борлуулах тал дээр асуудал үүсдэг аж. Уг нь, Инновацийн тухай хуульд төрөөс гарааны бизнес эрхлэгчдийг худалдан авалтаараа дэмжих заалт оруулжээ. Гэсэн ч энэ заалт амьдрал дээр хэрэгжиж чадахгүй байна. Жишээлбэл, Монголын хэрэгцээг



С.Батсайхан / ЗГМ©

хангахад бордоо үйлдвэрлэдэг компаниудын хүчин чадал хүрдэггүй гэсэн шалтгаанаар импортын бүтээгдэхүүн худалдан авдаг юм байна. Оюуны өмч дээр суурилсан мэдлэгийг баялаг болгох бизнесийг ижил төстэй импортын хямд бүтээгдэхүүнтэй зүйрлэж болохгүй. Жижиг үйлдвэрлэлтэй тохиолдолд нэгж бүтээгдэхүүний зардал өндөр гарах нь ойлгомжтой. Тиймээс өндөр өртөгтэй бүтээгдэхүүнд зах зээлд импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөнө гэдэг боломжгүй. Иймээс төр худалдан авалтаараа гарааны компаниудыг дэмжих хэрэгтэй байна. Улсад нэг сая тонн бордоо хэрэгтэй болбол

эхний 100 мянган тонныг нь гарааны компаниас бодлогоор дэмжин авч, үлдсэнийг нь импортлож болно шүү дээ. Ингэснээр энэ жил 100 мянган тонныг үйл ажиллагаагаа өргөжүүлж компани дараа жил нь үйлдвэрлэлээ өргөтгөж, 200 мянган тонныг гэх мэтээр бүтээгдэхүүний гарцаа ахиулаар, таван жилийн дараа дотоодын хэрэгцээг бүрэн хангах тэнхээтэй болчихно.

Инновацийн тухай хуулийн шинэчлэлийн асуудлыг ярьж байгаа энэ үед Инновацийн сан байгуулах зайлшгүй шаардлагатайг гарааны компаниудын төлөөлөл хэлж байна.

Ингэснээр гарааны бизнесийн төсөлд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох зөв системд шилжих боломж бүрдэнэ. Эдийн засгийг солонгоруулах үндэс бол шинжлэх ухаанд суурилсан, мэдлэг шингэсэн баялаг бүтээх үйл ажиллагаа. Тиймээс инновацийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож, гарааны бизнесийг төрөөс дэмжих бодлогоо тууштай баримтлах хэрэгтэй болоод байна. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

-Гарааны компаниудад төрөөс ямар дэмжлэг үзүүлж байна вэ?

“Гарааны Монгол экологийн бордоо” компанийн захирал

А.Чойжамц:

-ХААИС-ийн эрдэмтэд 1996 оноос Монголд байгаа бордооны түүхий эдийн судалгаа хийсэн. Бидний хийсэн судалгаа Шинжлэх ухаан технологийн сангийн шалгаруулалтад тэнцэж, 2011-2013 онд экологийн цэвэр бордооны инновацийн төслийг хэрэгжүүлсэн. Инновацийн төслийн судалгааны үндсэн дээр “Монгол экологийн бордоо” компани байгуулж, өнгөрсөн онд долоон тэрбум төгрөгөөр үйлдвэрээ байгуулсан. Инновацийн тухай хуулийн дагуу гарааны компанийн болзол хангасан. Бид газар тариалангийн салбарт 600 мянган тонн бордоо нийлүүлээд байна. Тасралтгүй ажиллавал жилд 30 мянган тонн органик бордоо үйлдвэрлэх чадалтай. Импортын бордооноос манайх 50-100 мянган төгрөгөөр хямд. Гэтэл төр засгаас гарааны бизнесийг дэмжихгүй байна. Уг нь, гарааны компани инновацийн, эрдэм шинжилгээний ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа. Энэ утгаараа төр засгаас тодорхой хэмжээний дэмжлэг авах нь зүйтэй.

“Гарааны Батсүмбэр зөгий” компанийн захирал

Г.Очирбат:

-Хөрөнгө оруулалтгүйгээр ямар ч гарааны бизнес хөгжихгүй. Тэртээ тэргүй жижиг компаниуд байгуулагдаж, бизнесийн хуулиараа үлдэх нь үлдэж, чадахгүй нь дампуурна. Харин гарааны буюу инновацийн

нэвтрүүлж буй компаниудад улсын төсөв, Шинжлэх ухааны фонд зэрэг эх үүсвэрээс тодорхой хэмжээний үйлдвэрлэл явуулахад нь шаардлагатай техник, технологийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Бидний хувьд өөрсдийн тав арван төгрөгөөрөө зөгий худалдан авсан. Гэхдээ улсаас ямар нэг дэмжлэг өгөхгүй байгаа учраас үйлдвэрлэл тэлэхгүй байна. Одоогоор хувь хүний санаачилгаар л энэ бизнес явж буй. Түүнээс биш, улсад дорвитой хувь нэмрээ оруулах хэмжээнд хүртлээ хөгжихгүй байна.

“Гарааны праймер” компанийн захирал

С.Лхагвасүрэн:

-Манайх хоёр жил дараалан инновацийн төсөл авахаар материалаа өгсөн. Төрийн зарим албан хаагч инновацийн бүтээгдэхүүнийг талхтай адил гэж ойлгоод байх шиг. Шинжлэх ухааны салбар хийх ёстой ажлаа дэмжихгүй, мөнгө олох ажлыг дэмжих сонирхолтой байгаа нь харамсаар. Тухайлбал, манайх лабораторийн оношлуур хийсэн. Энэ оношлуур нэг өвчний үүсгэгчийг 3-7 хоногт баталгаатай оношилдог. Гэтэл үүнийг зах зээл байхгүй гэсэн нэрийдлээр төсөөс хасчихсан. Зах зээлд хэрэгтэй бүтээгдэхүүнийг борлуулахад давуу талтай байж болох хэдий ч үнэн хэрэгтээ нарийн мэргэжлийн ажлыг төрөөс дэмжих ёстой. Шинжлэх ухааны байгууллага үүнийг ойлгохгүй бол, өөр хэн ч ойлгохгүй л дээ. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.05.23

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт удирдлагын нэгдсэн төвийн барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: УСҮГ-АҮ-2017-03-79

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос удирдлагын нэгдсэн төвийн барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 200,000 /хоёр зуун мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- **Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын нотариат болон аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.**
- **Сүүлийн 3 жил буюу 2014-2016 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.**
- **Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил буюу 2015, 2016 оны дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 10 хувиас багагүй байх.**
- **Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувиас багагүй байхаар тендерийн баталгаа ирүүлнэ.**
- **Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл.**

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минутаас 09 цаг 30 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минут-аас нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157019-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 сарын 22 - ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Зорчигчийн хоолны 1 удаагийн аяга хэрэгсэл нийлүүлэх**

2 багц бүхий тендер

Багц 1: Халбага, сэрээ, хутганы иж бүрдэл, хуванцар аяга, зуушны тавагны хуванцар таг нийлүүлэх

Багц 2: Сэндвичний сав-ком нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **22/2017-М - X**

МИАТ ТӨХК нь эрх бүхий тендер оролцогчдоос Зорчигчийн хоолны нэг удаагийн аяга хэрэгсэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК –ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, 103 тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- **Борлуулалтын хэмжээ сүүлийн 1 жилд:** 150 сая төгрөгнөөс багагүй,
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 1-р багцад 120 сая төгрөгнөөс багагүй байх, 2-р багцад 50 сая төгрөгнөөс багагүй байх,
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жил:** 2015, 2016 он

Тендерийн хамт 1-р багцад 5,210,000 төгрөгийн, 2-р багцад 1,440,000 төгрөгийн тендерийн баталгааг тус тус ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 сарын 07-ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 сарын 07-ний өдрийн 10 цаг 50 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа дахь, МИАТ ХК –ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө Утас: 70049860, Факс: 70049919

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 сарын 22 - ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **23/2017-М - X**

МИАТ ТӨХК нь эрх бүхий тендер оролцогчдоос Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК –ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, 103 тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- **Борлуулалтын хэмжээ сүүлийн 1 жилд:** 100 сая төгрөгнөөс багагүй,
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 80 сая төгрөгнөөс багагүй,
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жил:** 2015, 2016 он

Тендерийн хамт 3,707,900 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 сарын 07-ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 сарын 07-ний өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа дахь, МИАТ ХК –ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө Утас: 70049860, Факс: 70049919

Технологи


Онлайн сурталчилгааны маргаантай ирээдүй

Хүсээгүй зар сурталчилгаанаас хэрхэн ангижрах вэ

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Хэрэглэгчид интернэт орчинд зар сурталчилгаан дундаас өндийхөөргүй болжээ. Онлайн талбар бол компаниудын хувьд бараа, үйлчилгээгээ сурталчлах, шинэ хэрэглэгч олох хямд төсөр хэрнээ үр дүнтэй арга болоод буй. Харин хэрэглэгчдийн хувьд энэ нь эсрэгээрээ. Цахим хуудас, веб сайтын хэрэглэгчид эрээлжилсэн олон зар сурталчилгаанд хахаж, түүнд дургүйцэх боллоо. Фэйсбүүк, Твиттер хуудсаас хэрэгтэй мэдээллээ олж уншихын тулд өдөрт хэдэн зуун рекламтай бид нүүр тулдаг. Гэнэт гарч ирсэн сурталчилгааг хаах, олон зураг, видео бичлэгийг ачаалах гээд багагүй цаг хугацааг үүнд зарцуулж байна. Хүн өдөрт дунджаар 5000 зар сурталчилгаа үздэг. Үүний олонхтой нь онлайн орчинд таардаг гэсэн судалгаа гарчээ. Тиймээс хэрэглэгчид хэрээс хэтэрсэн зар сурталчилгааг хязгаарлахыг интернэтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас шаардаж эхэлсэн. Үүний үр дүнд програм хангамжийн компаниуд зар сурталчилгааны эсрэг adblock програмыг бүтээсэн нь өдгөө хүчээ аваад байна. Энэ төрлийн

Adblock-ийн хэрэглээ 2013 оноос эрчимтэй өсөж, 2015 он гэхэд нийт интернэт хэрэглэгчийн 48 хувь нь ямар нэг хэмжээгээр ашигладаг болсон байв.



BVM©

програмууд нь веб серверээс браузер буюу хөтөч дээр ирж буй бүх мэдээллийг хэрэглэгчид харуулахаас өмнө асар богино хугацаанд шүүдэг. Ингэхдээ хөдөлгөөнт дүрс, автоматаар тоглогддог бичлэг зэргийг төрлөөс нь хамааран блоколж, бусдыг нь харуулах зарчмаар ажилладаг юм байна.

Adblock-ийн хэрэглээ 2013 оноос эрчимтэй өсөж, 2015 он гэхэд нийт интернэт хэрэглэгчийн

48 хувь нь ямар нэг хэмжээгээр ашигладаг болсон байв. Харин 2016 оны байдлаар АНУ-д 72 сая, Францад 13.2 сая хүн ийм төрлийн програм хэрэглэж, хүсээгүй зар сурталчилгаанаас ангижирч байна гэсэн судалгаа гарчээ.

Adblock бол компьютер, гар утас, таблет дээр ажил, амьдралаа амжуулдаг хүмүүсийн хувьд шинэ хэрэглээ биш. Энэ төрлийн анхны програмууд 10 гаруй жилийн настай. Бараг л

бүх интернэт хөтөч дээр нэмэлт програм хэлбэрээр суусан байдаг. Тухайлбал, Mozilla Firefox-ийн баруун дээд булан дахь цэснээс Add ons manager-Extension гэж сонгоод үзэхийг хүсэхгүй байгаа мэдээлэл, сурталчилгааны төрлөө зааж өгдөг. Өөрөөр хэлбэл, мэдээллийг хар, цагаан жагсаалтад ангилна гэсэн үг.

Зар сурталчилгаа түгээгчид илүү нарийн арга хэрэглэх болсныг дагаад adblock програмууд

ч бас илүү ухаалаг болж буй. Нэг хэсэг сурталчилгаан дээр дармагц шууд өөр хуудас руу үсэрдэг холбоос газар аваад байсан. Тэгвэл одоо ихэнх хөтөч ийм холбоосыг өчиггүй устгадаг болсон юм. Adblock анхандаа зөвхөн хөтөчийн нэг хэсэг, нэмэлт програм нь байсан. Харин одоо ийм төрлийн бие даасан програм, төхөөрөмжүүд бий боллоо. Хэрэв таны хөтөч дээр зар сурталчилгааг хаах

тохиргоо байхгүй бол ийм програмыг интернэтээс үнэгүй татах боломжтой.

Гэхдээ adblock-оос өөр зар сурталчилгааг шүүх олон арга бий. Мөн IP хаяг, домэйн нэр, хостын нэр зэргийг зааж өгснөөр тухайн хаягаас ирэх мэдээллийн урсгалыг хаах арга ч байдаг. Засгийн газар зар сурталчилгааг дагасан гэмт хэргээс иргэдээ хамгаалахын тулд мэдээллийг хөтөч дээр очихоос өмнө хаах боломжтой. Мөн интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд зарим төрлийн зар сурталчилгааг хааснаар сүлжээний хурд нэмэгдэж, хэрэглэгчийн тоогоо өсгөх боломжтой. Adblock-ийг ашигласнаар зөвхөн зар сурталчилгаа биш, түүний ард нуугдсан бусад хортой програмыг компьютерт нэвтрэхээс сэргийлдэг аж.

АППЛИКЭЙШ

WeChat-ийг өргөжүүлэх трэнд дэлгэрэв



Хятад залуусын дунд WeChat гар утасны аппликэйшнийг хөгжүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх санаачилга газар авч байна. Саяхан хэсэг залуус Apple-ийн бүтээгдэхүүнийг сүйтгэж, WeChat-ийг хэрэглэхийг уриалсан бичлэгээ социал сүлжээнд цацсан нь үүний илрэл юм.

Тус аппликэйшн удахгүй Google, Apple зэрэг гар утасны зах зээлийн томчуудтай хамтран ажиллаж магадгүй гэж салбарынхан таамаглаж байна. Тухайлбал, Google-ийн андройд

үйлдлийн системийг гар утсанд суухад WeChat давхар татагддаг байхаар яригдаж байгаа аж.

WeChat-ийн 930 гаруй мянган хэрэглэгчийн тал хувь нь өдөрт 90 минутыг уг аппликэйшнийг ашиглахад зориулдаг байна. WeChat нь ном унших, такси захиалах, төлбөр төлөх, зоогийн газраас хоол захиалах зэрэг өдөр тутмын амьдралыг хөнгөвчилдөг олон үйлчилгээгээрээ хэрэглэгчдийг татдаг. Тус компани хамгийн их орлогоо QR код ашиглан төлбөр төлөх үйлчилгээнээс олдог юм байна.

WeChat-ийг эзэмшигч Tencent Holdings компани нь 1500 ажилтантай бөгөөд тус аппликэйшнийг дагасан, эсвэл түүнтэй холбоотой бүтээгдэхүүн хийх хүсэлтэй 200 гаруй мянган хөгжүүлэгч байдаг аж. Tencent Holdings компани ч эдгээр хөгжүүлэгчээс шилдэг санааг нь ашиглахын тулд бүх талаар дэмждэг. WeChat-ийн програмын хэл нь бусдынхаас ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдаг учраас ийм олон хөгжүүлэгчтэй болж чаджээ. [ЗГМ]

ХЭРЭГЛЭЭ

Бичгийн машины товчлуур эргэн ирнэ



АНУ-ын гэр ахуйн цахилгаан бараа үйлдвэрлэдэг Elretron компани хуучны бичгийн машин шиг загвартай компьютерын гарыг худалдаанд гаргахаар эхэж байна. Penna нэртэй уг гар нь утасгүй, таблет, зөврийн компьютерт ашиглах боломжтой. Товчлуур нь яг л хуучны бичгийн машиныг товшиж буй мэт чимээ гаргадаг аж.

Энэ сарын эхээр захиалагч авч эхэлсэн Penna ирэх есдүгээр сард дэлгүүрийн лангуунд очно. Чихэвч, гэр зэрэг дагалдах хэрэгслээс хамаарч 110-900 ам.доллараар худалдаанд гарах юм. Цагаан, ягаан, хар, цайвар ногоон, бор зэрэг таван өнгийн сонголттой уг гарын өргөн нь 267.4 мм, өргөн нь 194.7 мм юм байна. [ЗГМ]

ЗӨВЛӨГӨӨ

Фэйсбүүкээ урилгагүй зочноос хамгаалах нь

Фэйсбүүк хуудаст аюулгүй байдлыг хангасан олон тохиргоо байдаг ч хэрэглэгчид тэр бүр мэддэггүй. Фэйсбүүкээр хэдэн ч газраас зэрэг орох боломжтой учраас таны акаунтаар өөр нэгэн нэвтрэх эрсдэл өндөр. Үүнээс сэргийлэхийн тулд таны хэрэглэгчийн эрхээр хэн нэгэн ормогц и-мэйл ирдэг тохиргоог хийгээрэй. Ингэхдээ Settings>Security>Login Alerts цэсийг идэвхжүүлнэ. Мөн өөр хүн давхар нэвтрэхээр оролдох үед и-мэйл илгээдэг Settings>Security>Login Approvals цэсийг сонгож болно.

Олон нийтийн газар фэйсбүүк хуудсаа нээлттэй орхих тохиолдол цөөнгүй гардаг. Энэ тохиолдолд акаунтаа хамгаалахын тулд Settings>Security>Where you are logged in цэсийг сонгож хаанаас, ямар IP хаягаас, хэзээ нэвтэрсэн болохыг хараарай. Үүний дараа мэдээллийн хажууд буй “End activity” товчлуурыг дарснаар таны нээлттэй орхисон хуудсаар дахин нэвтрэх боломжгүй болох юм. [ЗГМ]

Сурталчилгаанд мөнгө төлж буй компаниудыг алдагдалд оруулж байна

Програм хангамжийн компаниуд ийнхүү замбараагүй сурталчилгаанд зааг тавьж байгаа нь нөгөө талаас сурталчилгаанд мөнгө төлж буй компаниудыг алдагдалд оруулдаг. Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээс онлайн орчныг илүү үздэг дижитал маркетингийн хувьд adblock “дайсан” л гэсэн үг. Хамгийн сүүлд гэхэд Германы Die Zeit, Handelsblat зэрэг онлайн хэвлэлийн компани өөрсдийнх нь веб сайтын орлогод ихээхэн хохирол учруулж байна хэмээн Adblock plus компанийг шүүхэд өгчээ. Харин шүүхээс интернэт хэрэглэгчид дурын програмаа суулгах эрхтэй гэж үзсэн байна. Энэ нь зар сурталчилгааны компани болон adblock-ийг хөгжүүлэгчдийн хоорондох “дайн”-ы эхлэл ч байж болох юм.

Шүүлтүүрийн програм хүчээ авах хооронд зар сурталчилгаа түгээгчид ч зүгээр суугаагүй. Тухайлбал, Forbes сэтгүүлийн цахим хуудас хэрэглэгчдийнх нь хэд нь adblock програм ашиглаж буйг тоолж, бүртгэдэг. Ингээд шүүлтүүртэй хэрэглэгчдэд тус сэтгүүлийн мэдээлэл, сурталчилгааг бүрэн үзэхийн тулд уг програмаас татгалзахыг санал болгодог. Учир нь зарим хэрэглэгч интернэт хөтөч нь зар сурталчилгааг шүүж байгаа, эсэхийг мэдээгүй байдаг аж. Цаашид ч энэ мэт зар сурталчилгааны орон зайг хамгаалах гэсэн шүүлтүүрийн эсрэг үйлдлүүд улам олширно гэж судлаачид таамаглаж байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН

[мэдээллийн урсгалаас чухлыг нь]



Амьдралын хэв маяг

Цохиулдаггүй хүүхдийн IQ-ийн хөгжил өндөр байдаг

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Сүүлийн үед дэлхий нийтээрээ хүүхдийн хүмүүжилд анхаарал хандуулах болжээ. Европын судлаачдын хийсэн судалгаагаар хүүхдийн хүмүүжил төлөвшлийн 80-90 хувь нь эцэг эх, гэр бүлийн тусгал байдгийг тогтоосон байна.

Монголчуудын “Хүнтэй суухдаа удам судрыг нь сайн шинж” хэмээн хэлдэг нь оргүй хоосон зүйл биш юм. Учир нь тухайн хүний гэр бүлийнхэн ямар байхаас зан чанар, хүмүүжлийг тодорхойлдог. Хүүхдийн оюун ухааны цар хүрээг сургалт хүмүүжлийн аргаар тэлж өгдөг боловч хүний мөс чанар, зан авир, бие хүний шинж нь эцэг, эхээс хуулбарлагдан бий болдог аж. Хүүхдийг багаас нь цохиж, загнаж өсгөх нь IQ-ийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг байна. Хүүхдийг буруу зүйл хийлээ гээд цохиж шийтгэх нь тархинд их хэмжээний “стрессор” үүсгэдэг аж. Энэ нь айж, цочимтгой болох тархинд үүсэх гэмтлийг хэлдэг. Тухайлбал, долоо хоногт гурван удаа цохих нь бага насны хүүхдийн тархинд ноцтой гэмтэл үүсгэдэг байна.

Цохих нь бага насны хүүхдийн тархинд ноцтой гэмтэл үүсгэдэг

Ингэснээр хүүхдийн оюун ухааны хөгжилд саатал үүсгээд зогсохгүй үр дагавар нь насан туршид нь үргэлжилдэг байна. АНУ-ын Нью Хампшайрын их сургуулийн профессор Муррай Страус 2009 онд 2-4 насны 806, 5-9 насны 704 хүүхдийн IQ-ийн түвшинг тодорхойлжээ. Судалгаагаар эцэг, эх нь цохиж,



Б.Ганбаяр / ЗГМӨ

Толлин дахь таны тусгал

гар хүрдэг хүүхдийн IQ, нэг ч удаа цохиулж байгаагүй хүүхдийнхээ таван оноогоор дутуу байв. Харин 5-9 настай хүүхдийнх нь 2.8 оноогоор дутуу гарчээ. Үүний дараа бага насандаа цохиулдаг байсан 32 орны 17404 оюутны дунд мөн дээрх судалгааг хийсэн аж. Судалгаагаар бага насандаа цохиулдаг байсан оюутнуудын IQ-ийн түвшин ээж, аав нь огт гар хүрж байгаагүй оюутнуудынхаас бага байжээ. Дээрх судалгаа цохих тусам хүүхдийн оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлж буйг харуулжээ.

Гэтэл манайд болохгүй зүйл хийвэл загнаж, хүүхдээ цохих нь энгийн үзэгдэл болсон. Уг нь уламжлалт монгол ухаанд аав, ээж нар өөрийн биеэр үлгэрлэн дуурайж, бага наснаас нь ажил амьдралд сургадаг байсан бол өнөөгийн аав ээжүүд өглөөнөөс орой

хүртэл ажиллаж, үр хүүхдэдээ төдийлэн анхаарал хандуулж чадахгүй байна. Тийм ч учраас хүүхдээсээ хэтэрхий холдож, ямар хүн болж төлөвшиж буйг нь анзаардаггүй. Ажлын стресс, ядргаанаас болоод хүүхэдтэйгээ тоглож, цагийг өнгөрөөхөөс ч түвэгшээдэг. Жаахан зүйл буруу хийлээ гэхэд чанга дуугаар загнаж, цохиод авдаг. Тэгвэл гурван настайдаа өдөрт хоёроос дээш удаа цохиулж, зэмлүүлдэг хүүхэд таван насандаа түрэмгий зан ааштай болох магадлал 49 хувиар нэмэгддэг бөгөөд сургуульд орсон хойноо бусдыг дээрэлхэж, ширүүн зан авир гаргах нь нэмэгддэг.

Түүнчлэн насанд хүрсэн хойноо хань ижил, үр хүүхдэдээ ухаанаар биш, хүчээр ханддаг байна. Тэгэхээр эцэг, эхчүүдийн хүүхдэдээ өгч буй үлгэр дууриалал тэдний цаашдын амьдралын тусгал төдийгүй

оюун ухааны хөгжилд ч асар их үүргийг гүйцэтгэж байгаа юм. Тиймээс хүүхдийнхээ зурж буй зураг, бусадтай харилцах байдал, гаргаж буй зан аашийг нь сайтар ажиглаарай. Ингэснээр та хүүхдийнхээ ямар хүн болон өсөж торниж байгааг мэдэхээс гадна, оюун ухааны хөгжлийг нь ч тодорхойлох боломжтой. [ЗГМ]

» Хүний мөс чанар, зан авир, бие хүний шинж нь эцэг, эхээс хуулбарлагдан бий болдог.

» Хүүхдийг буруу зүйл хийлээ гээд цохиж шийтгэх нь тархинд их хэмжээний “стрессор” үүсгэдэг.

» Зурж буй зургаар нь хүүхдийнхээ оюун ухааны хөгжлийг тодорхойлох боломжтой.

ШИНЭ БҮТЭЭЛ “Бөмбөгөр ногоон”- ыхныг эргэн дурсахуй



Б.Ганбаяр / ЗГМӨ

“Урлагийн номын сан” байгуулахаар санаа сэтгэл нэгдсэн “Бадрангуй урлаг” ТББ-ынхан “Бөмбөгөр ногооны Б.Мушгиа”, “Алтан үе-Бөмбөгөр ногооныхон” нэртэй хоёр шинэ номынхоо нээлтийг Монголын театрын музейд хийлээ. Бөмбөгөр театрын анхдагчид болох алдартнуудаас номын дуу сонсож, дараа нь өөрөө мөнхүү театртаа туслах найруулагчаар ажиллаж, урлагт зүтгэсэн 50 гаруй жилийнхээ замналыг хүүрнэсэн “Бөмбөгөр ногооны Б.Мушгиа” номыг сэтгүүлч Д.Отгонбаяр эмхэтгэсэн аж.

Харин “Алтан үе-Бөмбөгөр ногооныхон” ном сэтгүүлч Н.Сарангэрэл, Ц.Энхмаа, түүхч С.Туяа нарын хамтын бүтээл. “Бөмбөгөр ногоон”-той холбоотой, урьд өмнө төдийлэн олны сонорт хүрч, хэвлэлд гарч байгаагүй олон сонирхолтой баримтыг энэхүү бүтээлд туурвижээ. Мөн Н.Сарангэрэл, Ц.Энхмаа нарын хувьд “Бөмбөгөр ногооныхон” буюу бидний нэрлэдгээр алтан үеийнхний түүхийг амьд сэрүүнд нь хэвлэлийн хуудаснаа буулгаж үлдээсэн ярилцлагуудаа эмхэтгэн багтаажээ. [ЗГМ]

Зөвлөгөө Таны энгийн үйлдэл ч маш чухал

Олон улсад хийгдсэн судалгаагаар чихэр буюу амттан нь тархийг идэвхжүүлдэг нь батлагдсан. Тиймээс хүүхдээ хичээл хийж байх, аль эсвэл түр завсарласан үед нь амттанаар баярлуулбал том шагнал болохоос гадна тархины үйл ажиллагааг сайжруулдаг байна.

Гэр бүлийн маргаанаас хол байлга. Гэр бүлийн тогтвортой харилцаанд сэтгэл дүүрэн, аз жаргалтай өссөн хүүхэд том болоод ажил амьдралдаа амжилт гаргадаг.

Хүүхдэдээ үзүүлэх итгэлийг нэмэгдүүлснээр түүний суралцах чадвар өсдөг байна.

Нэг цагийн дутуу ноир зургадугаар ангийн хүүхдийг өөрөөрөөгээр ангийн хүүхдэд ишг болгодог аж. Тиймээс хүүхдийг сайн унтуулж, амрааж байх нь маш чухал. [ЗГМ]

КИНО

Ц.Төмөрхуяг: “Cinema Awards” уран бүтээлчдийн хүлээлтийг хэд дахин давж чадлаа



«Арга хэмжээг дагаад шүүмжлэл ч бас байна. Энэ талаар юу гэж бодож байна вэ?»

-Монголд кино хөгжөөд ч байгаа юм уу, ийм шагнал гардуулах ёслол байх ёстой ч юм уу гэсэн хэмжээнд ойлгож байгаа мэр сэр хүмүүс байна. Киноны талаар ойлголт багатай хүмүүс ингэж яриад байдаг юм болов уу гэж боддог. Кино гэдэг бол хүмүүжил, боловсролын ач холбогдолтой. Өнөөдрийн нийгэмдээ аль болох тохируулж хийхийг зорьдог. “Cinema Awards” хийж байгаа зорилго бол мэдээж кино урлагийг дэмжих, дэлхийн хэмжээнд аваачих шүү дээ. Ийм арга хэмжээг зохион байгуулж байж киночид дунд өрсөлдөөн бий болно. Ингэснээр кино урлаг маань шат ахиж,

хөгжих үүд хаалга нээгдэнэ.

1990-ээд оны үед шинэ кино байхгүй, энэ урлаг алдагдчихсан байлаа. Одоо харьцангуй хийдэг болж. Сайн муу ч бай хийж л байх хэрэгтэй. Бүтээлүүдээ мэргэжлийн хүмүүсээр дүгнүүлдэг байлаа даа. Тэгээд ч кино урлаг хөгжино гэдэг өөрөө капитал. Сайн хөгжиж чадвал улсад орох орлого ч нэмэгдэнэ. Холливуудад хэдий хэмжээний мөнгө эргэлдэж байгааг бид харж байна. Улсын хөгжил гэдэг урлаг, спортоор тодорхойлогддог. Бид Олимпийн аваргагүй байсан бол Монгол Улсыг дэлхий дахинаа мэдэх үү. Үүн шиг урлагаа дэмжиж, “Cinema Awards” шиг арга хэмжээг зохион байгуулж, өрсөлдөөнийг бий болгох нь чухал. Хамт нэр дэвшсэн хүмүүстэй би их баярлаж байгаа.

Яагаад гэвэл өрсөлдөөнгүйгээр юм хэзээ ч ахидаггүй. Тиймээс тэдгээр хүмүүс надад урам хайрлаж, ахиж дэвших нөхцөлийг бүрэлдүүлж байгаа юм. Үүнд “Cinema Awards”-ийн ач холбогдол оршиж байгаа.

Кино урлаг хөгжинө гэдэг өөрөө капитал

Мөн нөгөө талаас чанартай, чанаргүй кино гэж их ярьж байна. Киногоо өрсөлдүүлж л байх хэрэгтэй. Олон кино байх тусам тэндээс чанартай сайн кино нь шалгарна болно. Намайг хүмүүс муу, сайн гэхгүй олон

кинонд тоглох юм гээд л хэлдэг. Яагаад би тоглодог вэ гэвэл залуу үе маань уран бүтээлч хийх гээд хичээж явна. Миний багшилж байсан хүүхдүүд кино хийж байна. Энэ нь кино урлаг сэргэж байгаагийн илрэл. Тэднийгээ дэмжих хэрэгтэй.

«Шагнал гардуулах үеэр та биечлэн байлцаж чадаагүй. Шагнал авсан гэдгээ сонсох тэр мөчийн сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?»

-Бүгд утсаар яриад, баяр хүргэсэн. Шагнал авахаараа бага зэрэг санаа зовоод байдаг хүн л дээ. Гэхдээ шагналд дургүй хүн гэж байхгүй. Маш надад санагддаг. Ингэж шагнуулж байгаа нь аав, ах хоёрын минь нэртэй холбоотой явдаг учир тун их талархалтай хүлээж авсан. Аав маань Цогт тайж кинонд

тоглоод Монгол Улсын анхны Ардын жүжигчин болсон. Ах маань 19-хөн насандаа Төрийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал агсны дүрийг бүтээгээд Төрийн шагнал хүртсэн. Тэднийхээ нэрийг хугалахгүй юмсан гэж хичээж явна. Нэг талаараа хүнд ачаа, үүрэг харууллага боловч нөгөө талаараа маш их аз жаргал юм даа. Анх удаа зохион байгуулагдаж байгаа “Cinema Awards” ёслолын үйл ажиллагаанаас анхны шилдэг туслах дүрийн шагналыг авч, анхдагчдын нэг болж байгаа нь их билгэшээлтэй зүйл боллоо.

«Ээж» кино хоёр номинацид шагнал хүртлээ. Мөн гаднын кино наадмаас шагнал авсан. Киноныхоо талаар, өөрийн бүтээсэн дүрийнхээ талаар ярихгүй юу?»

-“Ээж» киноны зохиол бичигдээд удаж байгаа. Засвар, сайжруулалт хийж явсаар ийнхүү кино болон дэлгэцнээ гарлаа. Би жүжигчнийхээ хувьд нэг юм хэлмээр санагддаг. Жижиг дүр гэж байдаггүй. Туслах дүр үргэлж гол дүрээ тодотгож өгдөг. Туслах дүргүйгээр гол дүр гэж байхгүй. “Ээж» кинон дээр тэр эвдэрчихсэн, замаа алдаж явсан залуугийн дүр эх хүнээс унасан гэдгээ хэзээ ч маргаж чадахгүй байна гэдгийг харуулж байгаа нь “Ээж» киног тодорхойлж байгаа юм. Найруулагчаар соёлын тэргүүний ажилтан, жүжигчин Б.Эрдэнэцэцэг ажилласан. Их дайчин бүсгүй. Холливуудын эмэгтэй жүжигчдийн арга зүйгээр явж байгаа юм шиг надад санагддаг. Кино баг маань ажилдаа гаршсан, сайн хамт олон бүрэлдсэн. Тиймдээ ч гаднын кино наадмаас шагнал хүртсэн гэхэд хилсдэхгүй. Ер

нь Монголын киночид маань мэргэжлийн түвшинд хүрч байна.

«Эмэгтэй гол дүрийн шагналыг Монгол Улсын ардын жүжигчин Д.Мэндбаяр гуай хүртсэн. Энэ сайхан жүжигчний талаар сэтгэгдлээ хуваалцаач?»

-Би 1984 оноос эхэлж Драммын театрт ажилласан. Энэ хугацаанд олон жүжиг, уран бүтээлүүдэд хамтарч ажиллаж байлаа. Их бага залуугаасаа Мэндээ эгч Цэрэндагва ах хоёрыг мэднэ. Үнэхээр хөдөлмөрч хүмүүс. Мэндээ эгчийн нэг гайхалтай чанар нь их олон ээжийн дүрийг бүтээсэн байдаг. Олон ээжүүдийг ялгаатай хийж чаддаг нь жүжигчний ур чадварыг харуулж байгаа юм. Хүнийхээ хувьд их сайн хүн. Тиймээс ч энэ дүрийг ийм сайн бүтээсэн гэж бодож байна. Алтан үеийнхэн бидэнд “Чи эхлээд хүн бай. Тэгвэл жүжигчин болж чадна” гэж сургадаг. Жүжиглэнэ гэдэг нь хүн судлал учир арга ч үгүй биз.

«Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа. Улам их амжилт хүсье.»

-Та бүхэнд ч бас баярлалаа. Мөн “Cinema Awards” ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, Монголынхоо киночдыг дэмжин, өргөн дэлгэр сайхан арга хэмжээ зохион байгуулсан “Нью Тур Сафарис” ХХК болон “Кино урлагийн зөвлөл”-ийн хамт олонд баярласнаа илэрхийлье. Үйл ажиллагаа амжилттай болсонд мөн баяр хүргэе. Цаашдаа энэ арга хэмжээгээ улам баяжуулж, хүсэн хүлээдэг кино наадам болгоорой гэж ерөөе.

Лавлах

НИЙСЛЭЛ Дугуйт эргүүлтэй боллоо

З.Гэрэл
ЗГМ

Нийслэлийн Цагдаагийн газраас хэрэгжүүлж буй “Эргүүл” дэд хөтөлбөрийн хүрээнд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэл хотын хэмжээнд “Дугуйт эргүүл” ажиллаж эхэллээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажлыг олон улсын цагдаагийн байгууллагын жишигт хүргэж, эргүүлийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд уг хөтөлбөрийн зорилго оршиж байгаа аж. Түүнчлэн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан морь, нохойг эргүүл ажиллуулахаар төлөвлөжээ.

Нийслэлд байнгын эргүүл ажиллаж эхэлснээр гэмт хэргийн гаралт, ялангуяа гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурсан байна. 2017 оны эхний дөрвөн сард бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 16 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 14 хувиар буурчээ. Мөн бусдын эд хөрөнгийг булаах 34, дээрэмдэх 17, бусдын эд зүйл хулгайлах 28.8, танхайрах гэмт хэрэг 20 хувиар тус тус буурсан байна. [ЗГМ]

ҮЙЛЧИЛГЭЭ Хөтчийн үнэгүй сургалтад хамрагдаарай

Гадаад хэлний зохих мэдлэгтэй, хөдөлмөр эрхлээгүй оюутан, залуучуудыг жуулчны хөтөч бэлтгэх сургалтад үнэ төлбөргүй хамруулахаар болжээ. Энэ сарын 26-наас ажлын таван өдөр болох “Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх” сургалтаар жуулчдад үйлчлэх аяллын хөтөчийн мэргэжлийн арга зүйг олгох юм байна. Ингэснээр жуулчны хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, эх орныхоо соёлын дурсгалт газрын талаар өргөн мэдлэгтэй болохоос гадна хувь хүний хөгжилд хэрэгтэй мэдлэг, мэдээллүүдийг өгөх юм.

Нийслэлийн Иргэний танхимд явагдах уг сургалтаар хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд орохыг горилогчийн эрх үүргийн талаар болон жуулчин хүлээн авах бүхий л арга зүй, ур чадварыг сургах юм байна.

Сургалтад хамрагдах хүсэлтэй залуучууд ubyouthdevelopment@gmail.com хаягаар бүртгүүлж, холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын цахим хуудаснаас авах боломжтой. [ЗГМ]

ТОХИЖИЛТ Таван хороо нано халаалттай болжээ


Дэлхийн хамгийн хүйтэн нийслэлийн нэг Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн таван хороонд БНСУ-ын “Экопарт-нерс” компанийнхан нано технологийн халаалтын систем туршилтаар суулгасан байна.

Уг төхөөрөмжөө агаарын бохирдол хамгийн ихтэй хорооны сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв болон тодорхой тооны айл өрхөд үнэгүй суурилуулжээ. Нано халаалтын давуу тал нь өрөөг хүссэн градус хүртлээ халаах бөгөөд агаарыг хуурайшуулахгүй, элдэв нян бактерийг 100 хувь устгахаас гадна аюулгүй ажиллагааг бүрэн хангасан тул бага насны хүүхдийн хурууг түлэхгүй аж. Мөн халаалтын температураа өөрөө тохируулдаг бөгөөд өрөөний дулаан заасан хэмжээнээс хэтэрвэл өөрөө унтарч, асдаг ухаалаг эд юм байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Людмила Гурченко” Оросын уран сайхны кино 6 дугаар анги	07.00 “Америк хэрхэн ажилладаг вэ” нэвтрүүлэг	08.05 ЕБС-ийн теле хичээл	09.30 Тог тог тог (season 4) 26 дугаар хэсэг
12.00	11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр /шууд/	11.10 “Студио 1.0” нэвтрүүлэг	11.15 “Мердокийн тайлагдашгүй нууцууд” ОАК 1.4 дүгээр анги	11.40 “Нугасны муухай дэгдэхэй” хүүхэддэйн кино 6 дугаар анги
14.00	14.00 “Цэлмэг” өдрийн хөтөлбөр /шууд/	14.00 “Айн Рэнд конференц 2017-1” нэвтрүүлэг	13.10 “Яг түүн шиг” шилдэг найм (Г.Мэнд-Амар, Б.Ариунцэцэг)	14.00 “Египетийн түүх” баримтат кино 5 дугаар хэсэг
18.00	21.05 Цаг үе үзэл бодол /шууд/	17.00 “Bloomberg Surveillance”	17.05 Кино миний амьдрал	17.00 “Жимсхэн охид” хүүхэддэйн кино 15 дугаар анги
20.00	21.05 “Хууль батлагдахын өмнө” тоймчийн хөтөлбөр	20.00 “Made In Mongolia: Seaberry ХХК” нэвтрүүлэг	19.00 “Сэвэлзүүр салхи” ОАК 48 дугаар анги	20.00 Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
22.00	22.55 “Монгол өв соёл” хөтөлбөр	22.00 “Эзэнт гүрнийг босгосон нь” нэвтрүүлэг	21.00 “Зөв үнийг таа” шоу нэвтрүүлэг	22.30 “Чадвал намайг хуур” ОАК 44 дүгээр анги

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



нэр ширээ
16. Явган цэргийн байлдааны хуягт машин
ХӨНДЛӨНГӨӨР:
3. Хүлээсэн хариуцлага
5. АХ-ын 40 жилийн ойн баяр наадамд түрүүлсэн даян аварга

6. Дугуйн спортын хамгийн том тэмцээн “Тур де Франс”-д таван удаа түрүүлсэн Францын алдарт дугуйчин
7. Говь, талын гөрөөс
8. Африк тивийн Гвинейн буланд орших улс

11. Дэлхийн долоон ноён оргилд гарсан МУГТ уулчин эмэгтэй
12. Хувьсгалт Монгол Улсын цэргийн яамны анхны сайд
17. Үе мөчний өвчин
18. Амттан



Өмнөх дугаарын харуу /05.22

ЗГМ: СҮДОКУ


6	1					4
				6	5	8
			3	4		1
	6				2	
	8	4				
	4		7	5		9
			8	2	3	
1	2				9	
				5	6	

6	8	7	2	9	4	5	3	1
9	1	4	6	5	3	2	8	7
3	5	2	7	1	8	4	6	9
8	3	9	1	4	5	6	7	2
7	4	5	9	6	2	8	1	3
2	6	1	3	8	7	9	5	4
4	2	6	5	7	1	3	9	8
1	9	3	8	2	6	7	4	5
5	7	8	4	3	9	1	2	6

(Өмнөх дугаарын харуу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	V.23	V.24	V.25	V.26	V.27
	24° 5°	27° 8°	31° 12°	29° 13°	24° 12°
Багавтар үүлтэй	8 м/с 5 м/с	7 м/с 5 м/с	7 м/с 4 м/с	8 м/с 5 м/с	10 м/с 5 м/с



ТОХИЖИЛТ Таван хороо нано халаалттай болжээ

[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT”
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

**УНШИГЧ ТА МАНАЙ
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,
СУРВАЛЖЛАГАТАЙ
ХОЛБООТОЙ САНАЛ
ХҮСЭЛТЭЭ**

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН....

Хүүе чи яагаад буцаад ирэв ээ?

Ажлын байрны осол гээд акттай чөлөө авчлаа.

Айн юу болсон юм бэ?

Эвшээж байгаад эрүү мултарцан.

ОНЦЛОХ ҮЗВЭР

“Буратино - Алтан түлхүүр”



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан багачуудад зориулсан “Буратино-Алтан түлхүүр” жүжиг ирэх сарын 1-нд 13.00 цагаас The Corporate Hotel & Convention Centre-ийн концертын танхимд ганцхан удаа тоглоно. Ирсэн хүүхэд бүр гарын бэлгэтэйгээс гадна гэнэтийн бэлгээр дүүрэн байх энэ тоглолтын тасалбарын үнэ 40-45 мянган төгрөг. ЗХУ-ын зохиолч А.Толстойн “Буратиногийн адал явдал” зохиолоос сэдэвлэн, ардын жүжигчин С.Сарантуяа “Алтан түлхүүр” хүүхдийн жүжгийг найруулсан байна. Сургажигч үлгэрийн жүжигт үе үеийн хүүхэд багачуудын сайн мэдэх урт хамар, шовгор малгайтай дүрсгүй модон хүү Буратиногийн тухай өгүүлэх ба түүнийг аав Карло, найрагч Пьеро, цэнхэр үст Мальвина, урт сахалт Карабас Барабас гээд олон сонирхолтой дүрээр жүжгийн үйл явдал сонирхолтой өрнөх болно. [ЗГМ]

ҮЗВЭР

УДБЭТ
Дэлхийн алдарт “Дэггүй Лиз” хошин балет энэ сарын 27-нд 17.00 цагаас тоглоно.

УЛСЫН ФИЛАРМОНИ
Шилдэг хүүхэддэйн киноны хөгжмийн дээжээс “Баянмонгол Биг бэнд” хамтлаг түүвэрлэн “Танил ертөнц” хэмээх тоглолтыг тавдугаар сарын 31-нд 15.00 цагаас толилуулна.

УДЭТ
Төрийн соёрхолт Н.Наранбаатарын найруулга, С.Жаргалсайханы зохиол “Хэлж зүрхлээгүй хайр” уянгын драмын жүжгийг ирэх сарын 3-нд 18.00 цагт тоглоно.

ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТР
Ардын жүжигчин, төрийн шагналт Ц.Сэвжидийн нэрэмжит “Хүүхдийн ертөнц” бүжгийн тоглолт ирэх сарын 1-нд болно. Тоглолт “Хүүхэддэй”, “Өвөөгийн гутал”, “Ботгочин”, “Нарын домог” зэрэг бүжгийн жүжгийг тоглоно.

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМАРЛТЫН ХҮРЭЭЛЭН
Монголд анхдагч S L entertainment K-POP сонирхогч хүүхэд, залууст зориулан хамгийн том K-POP Mongolia хөгжмийн фестивалийг зохион байгуулах гэж байна. Фестиваль ирэх сарын 25-нд 17.00 цагт болно.

ОРШИЛ РЕСОРТ
Улаанбаатар хотоос 30 км, Гачууртын эцсээс 17 км-т байрлах Оршил ресортод энэ сарын 27-нд “Better day” спорт, урлагийн арга хэмжээ болно.

ZIFERBLAT
Амьд хөгжмийн “Cold play” хамтлагийн ковер тоглолт энэ сарын 27-нд болно. Тоглолт “Andromeda”, “Caffeine” хамтлагууд оролцох юм. Тасалбарын үнэ 8000 төгрөг.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 27
Хаврын адаг хөх луу сарын гурван хөх мэнгэтэй цагаан нохой өдөр.
Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 05.13-20.32
Барилдлага: Рашаан
Шүтэн барилдлага: Хүчин төгсөх
Суудал: Төмөр

Аргын тооллын тавдугаар сарын 23. Ангарга гаргаг. Билгийн тооллын 27, Шийдэм одтой, цагаан нохой өдөр.

Өдрийн наран 05.13 цагт мандан, 20.32 цагт жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүлшгүй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хуврага болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, лус тахи, хүүхэд үрчлэн авах, тангарагаа буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

ГАЛТ ТЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Москва	13.50	14.28
Москва-УБ	21.35	07.30
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
Сайншанд-УБ	20.25	07.01
УБ-Сайншанд	09.15	19.15

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Хонконг	06.25	10.55
УБ-Ханбумбат	07.20	08.30
УБ-Сөүл	08.45	12.50
Ханбумбат-УБ	09.20	10.25
Хонконг-УБ	12.05	16.45
Сөүл-УБ	14.20	16.50
УБ-Бээжин	17.55	20.10
УБ-Ханбумбат	20.00	21.10
Бээжин-УБ	21.10	23.40
Ханбумбат-УБ	22.00	23.05

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Ерөнхийлөгч Мун танхимаа томиллоо

Ноён Мун тус улсын бизнес орчинд агаар оруулж, чазбол хэмээх гэр бүлийн корпорациудыг өөрчлөхөөр төлөвлөж байна. > 10

Трампын анхны гадаад айлчлал

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп бямба гарагийн өглөө Рия хотод буух Саудын Арабын Ван өөрийн биеэр угтан авлаа. > 10

Японы эзэн хааныг залгамжлагч цөөрсөөр

Гүнж Мако энгийн хүнтэй сүй тавьсан нь Японы эзэн хааны гэр бүлд үе залгамжлах болон хүйсийн асуудлыг ил болголоо. > 10



Дональд Трамп, тэргүүн хатагтай Меланиа Трамп нар олон улсын анхны айлчлалдаа мордож буй нь.

Дордсоор буй Саудын Араб-Ираны харилцаа

Дайсагласан харьцаа чинээн-дээ туллаа. Саудын Арабын угсаа залгамжлах дэд ханхүү Мохамед бин Салман саяхан өгсөн ярилцлагадаа Ирантай хэлэлцэн тохиролцоо саналыг эрс няцаав. Тэрбээр хоёр улсын хоорондох шууд бус зөрчил мөргөлдөөн удахгүй шууд болж хувирах магадлалтай хэмээн тайлбарласан юм. “Бид тэмцэл Саудын Арабын нутагт өрнөхийг хүлээж суухгүй, харин ч Иранд үргэлжлүүлэхийг чармайна” хэмээн зарлав. Ираны тал хариуд нь хилэнт мэдэгдэл гаргасан нь мэдээж.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампыг бямба гарагт Риядад элэгсэг дотно хүлээн авсан нь хоёр тал хоёулаа Ираны талаар сэтгэл түгшиж буйн илрэл. Гэхдээ Саудын Араб нь АНУ-ын хувьд хэр зэрэг холбоотон байж чадах нь бүрхэг. Учир нь газрын тосны үнэ унагах өрсөлдөөнөөс үүдэн Саудын Арабын эдийн засаг хүндэрч, ажилгүйдэл ихсэн, авлига, тэгш бус байдал гаарсны дээр тус улс Йеменд Иран улстай прокси дайн өрнүүлж байгаа. Саудын Арабыг өөрчлөн шинэчлэх ханхүү Мохамедийн төлөвлөгөөнд улс төр, нийгмийн консерватив хүчин, боловсролын сул дорой тогтолцоо, угсаа залгамжлагчдын хоорондох тэмцэл саад болсоор.

Иран ч гар хумхин суусангүй. Ерөнхийлөгч Хасан Рухани өөрөөс нь илүү консерватив үзэлтэй өрсөлдөгчөө шийдвэртэй ялж, дахин сонгогдлоо. Ноён Руханигийн ялалт нь тус улсын цөмийн хөтөлбөрөөс үүдэлтэй хоригийг 2015 онд цуцалснаас хойш үүссэн эдийн засгийн

таатай нөхцөлийн үр дүн юм. Ираны сонгуулийн дүнд үндэслэн тус улсад аядуу хүчин эрх барих нь хэмээн тайлбарлах шинжээч цөөнгүй. Гэвч энэ нь байдлыг хэт хялбарчилж ойлгосон хэрэг. Аядуу үзэл гэдэг тун ч харьцангуй ойлголт. Үүний зэрэгцээ хүн амын 40 хувийн дэмжлэг бүхий консерватив удирдагчид Ираны төрийн мэдлийг атгасан хэвээр байгаа. Иранд ойрын ирээдүйд шинэчлэл өрнүүлэх боломж хязгаарлагдмал, улс төрийн гибрид тогтолцоотой орших бололтой.

Үүний зэрэгцээ Хезболла, Хамас зэрэг зэвсэгт бүлэглэлийг ашиглаж, шууд мөргөлдөөнд турхирагч эзэрхэг гадаад бодлого тус улсад өв болж үлдсэнгүй харгалзах ёстой. Иран улс нэгэнт олж авсан зүйлээсээ ухрах ямар

ч амлалт сонгуулийн кампанийн үеэр өгөөгүй. Энэ нь Йемений зэвсэгт мөргөлдөөн сунжран, Асадын дэглэм цаашид оршиж, Сирийн дайн гааран, тус бүс нутагт нөлөөгөө тогтоохын төлөөх тэмцэл хурцадна гэсэн үг. Саудын Араб болон түүний консерватив суннит холбоотнууд АНУ-аас шинэ зэр зэвсэг худалдан авлаа ч Ираныг амархан шахаж дөнгөхгүй. Эцсийн үр дагаврыг нь харгалзах аваас ноён Трамп ч Ираны эсрэг байр сууриа өргөн цар хүрээтэй бодлого болгон өргөжүүлэх боломж бараг байхгүй.

Юутай ч Саудын Араб, Ираны харилцаа сайжрах шинж одоогоор алга. Харин ч угсаа залгамжлах дэд хунтайжийн сануулсанчлан байдал дордож болзошгүй.

Дээдсийн явуулгын шинэ ертөнц

Габриэл Вилдау

Хятадын хөөгдмөл магнат Гуо Вэньгуй коммунист намын дээд удирдлага, тэдний хамаатан садны авлигын хэргийн талаар Twitter-т жиргээгүй үедээ гэрэл тавдугаар авеню дахь байрныхаа хүнд амьдралыг хөнгөвчилдөг. Ноён Гуо нь БНХАУ-ын хүсэлтээр Интерполоос гаргасан “улаан санаамж”-ийн дагуу эрэн сурвалжлагдаж буй хүн. Гэхдээ л тэрбээр Кардашаны амьдралаар амьдарч, яхт онгоцноо зургаа татуулан, Палм-Бич дэх Дональд Трампын Мар-а-Лаго гольфийн резортод тоглогч гишүүдийн нэг.

Хятадын дээдсийн өргөөнд дэх элдэв явуулгын дүр төрх хувирчээ. Өрсөлдөгч бүлэглэлүүд мэдээллийн хэрэгсэл болон ноён Гуо шиг итгэмжлэгдсэн хүмүүс ашигладаг болсонтой уялдан хаалттай хаалганы цаана далд явагддаг хоорондын тэмцэл нь улам бүр нийтэд ил, онлайн өрнөж эхлэв.

Энэ оны эцсээр Хятадад улс төрийн өөрчлөлт өрнөх тул цаашид ч дуулиантай хэрэг хэсэгтэй үргэлжилнэ. ХКН-ын ерөнхий нарийн бичгийн даргаар улиран сонгогдох төлөвлөгөөтэй, БНХАУ-ын дарга Ши Жиньпин эрх мэдлээ бэхжүүлэхийн тулд ХКН-ын УТТ-ны Байнгын хороонд өөртөө үнэнч шинэ гишүүд оруулахаар бэлтгэж байгаа. Түүний өрсөлдөгчид ч ижил зорилготой. Улс төрийн өрсөлдөгчийнхөө нэр хүндийг унагахад мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглаж болдгийг популист од Бо Шилайн уналт урьд нь харуулсан. ХКН-ын удирдлага солигдсон таван жилийн өмнө анх хэрэглэсэн энэхүү аргыг өрсөлдөж буй хоёр тал ч ашиглахаар анаж байгаа. Өрсөлдөгчөө түлхэн унагаж дийлээгүй тохиолдолд итгэмжлэгдсэн хүн ашиглах нь өөрийгөө хэрэгт холбогдолгүйг батлах баталгаа болж өгнө.

Ноён Шигээс өрнүүлж буй авлигын эсрэг хайр найргүй кампанид нь улс төрийн нарийн тооцоотой цэвэрлэгээ ч болж өгдөг. Тэрбээр өөрөө авлигын эсрэг кампани “барыг нь ч, баганыг нь ч үлдээхгүй” хэмээн амалсан. Хятадын төрийн телевизэр энэ онд дамжуулсан “Ард түмний нэрээр” цуврал кинонд бяцхан хотоос хальж Бээжин дэх төрийн ордонд нөлөөгөө өргөжүүлсэн авлигачийн эсрэг тэнцвэргүй тулаан өрнүүлж буй хууль сахиулагчийн тухай гардаг. Уг шоу кинонд бүр доод зиндааны “батгана”-аас эхлэн мөрдсөн хэрэг эцэстээ “бар” луу хөтөлж авчдаг.

Харин ноён Шигийн авлигын

эсрэг кампанийг шүүмжлэгч хүмүүс бодит амьдрал дээр авлигыг мөрдөн шалгах явц эсрэг чиглэлд өрнөдөг талаар тайлбарлав. Мөрдөгчид эхлээд “бар”-ыг хараална. Дараа нь түүнд үнэнч “батгана”-уудыг шахсаар “бар”-ын эсрэг баримт гаргуулж авна.

Ноён Гуо нь Хятад дахь авлигатай тэмцэх кампанийн уламжлалыг эвдэхээр аз үзэж буй нэгэн. Тэрбээр ХКН-ын авлигын эсрэг агентлагийн тэргүүн, Хятадаа хоёр дахь гол хүчирхэг хүн гэгддэг Ван Чижань руу тэмцлийнхээ хурц үзүүрийг чиглүүлжээ. Ноён Гуо одоогоор баримт нотолгоо гаргасан зүйлгүй. Гэхдээ Ван Чижаний байр суурийг сулруулж дөнгөвөл энэ оны удирдлагын сонгуульд шууд нөлөөлж, улмаар түүнийг хоёр дахь таван жилдээ УТТ-ны Байнгын хорооны гишүүнээр үлдэхэд нь саад учруулна.

Хятадын санхүүгийн салбарын дээдсийг доргиосон, хэд хэдэн хэрэг, баривчилгаа энэ онд болсон. Хятадын аюулаас хамгаалах албаныхан энэ онд тэрбумтан, санхүүч Сяо Жяньхуаг Хонконг дахь Four Seasons зочид буудлаас хүчээр авч явжээ. Мөн Хятадын даатгалын зохицуулах байгууллагын дарга байсан Сян Жуньбог авлигын хэргээр баривчилсан.

Waldorf Astoria-г эзэмшигч, даатгалын хөөргөн конгломерат – Anbang ч ХКН-ын дээд эгнээнд өөрийн гэсэн өмөг түшигтэй гэсэн цуу нийтэд түгээмэл. Anbang санхүүгийн заль мэх хийж буй талаар Хятадын санхүүгийн бие даасан гол вэбсайт Caixin өнгөрсөн сард уртаас урт тайлан нийтлэсэн нь улс төрийн далд явуулга байж тун ч болзошгүй.

Тулгасан хэргийг үгүйсгэж буй Anbang групп Caixin вэб-сайт, ерөнхий редактор Xu Шули нарыг шүүхэд өгөх гэж байгаага мэдэгдлээ. Хятадаа хэлхээ холбоо хамгийн сайн сэтгүүлийн нэг, хатагтай Ху уг материалыг сайтдаа нийтлэсэн нь улс төрийн салхи Anbang-д ивээлгүй болсны илрэл хэмээн зарим нь тайлбарлав. Материал нийтлэгдсэнээс хойш хэдхэн хоногийн дараа, Хятадын даатгалын зохицуулах байгууллага Anbang группийн шинэ бүтээгдэхүүн борлуулах эрхийг гураван сараар хасчээ. Тус групп зах зээл дээр “будлиан тарьж байна” хэмээн зохицуулах байгууллага буруутгасан байна. Хятадын улс төрийн элитүүдийн хувьд “хоолойдоо хутга тулгаатай” явах нь байнгын зүйл ч гаднын ажиглагчид далайхан хутгыг нь тэр бүр харж амьдаггүй юм.

Швейцарь цөмийн шинэ цахилгаан станц байгуулахыг хориглоно

Ральф Аткинс

Швейцарийн иргэд ХБНГУ-ын жишээгээр эрчим хүчний шинэ стратегид нийцүүлэн цөмийн эрчим хүчнээ аажим салахаар санал нэгдлээ. Тус улс цөмийн эрчим хүчний хэрэглээг хумих хэрээр нар, салхины эрчим хүчний хэрэглээг өсгөхөөр төлөвлөж байна.

Ням гарагт зохион байгуулсан санал хураалтад оролцогчдын 58.2 хувь нь шинээр цөмийн цахилгаан станц байгуулахыг хориглохын төлөө байгаа юм. Гэхдээ Альпийн улсад эдүгээ ажиллаж буй цөмийн таван цахилгаан станцыг аюултай гэсэн дүгнэлт гарахгүй л бол цаашид үргэлжлүүлэн ашиглана.

Японы Фүкүшимагийн цөмийн

цахилгаан станцад 2011 онд гарсан ослын дараахан ХБНГУ-ын иргэд санал хураалт явуулж, эдүгээ ажиллаж буй 17 АЦС-ыг 2022 он гэхэд бүгдийг нь хаахаар шийдвэрлэсэн. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Эммануэль Макрон цөмийн энергийг шүүмжлэгч Никола Юлог Эрчим хүчний сайдаар томилсон тул Францад ч АЦС-ын ирээдүй бүрхэг болж хувирлаа.

Усан цахилгаан станцад голлон түшиглэдэг Швейцарь улсын нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 30 гаруй хувь нь АЦС-д оногддог.

Швейцарийн сонгогчид тус улсын Ногоон намаас дэвшүүлсэн, цөмийн эрчим хүчнээ шуурхай татгалзах төлөвлөгөө

өнгөрсөн арваннэгдүгээр сард эсэргүүцжээ. Ногоон нам Швейцарын АЦС-ыг ердөө ирэх оноос эхлэн хаах замаар 2029 он гэхэд цөмийн эрчим хүчнээ бүрмөсөн ангижрах саналтай байгаа юм. Гэхдээ энэ удаад Бернийн Засгийн газрын эрчим хүчний стратегийг байгаль хамгаалах группүүд нийтээр дэмжлээ.

Шинээр цөмийн цахилгаан станц байгуулахыг хориглох нь Ногоон намын хувьд “амин чухал шаардлагын нэг” хэмээн Швейцарийн Ногоон либерал намын тэргүүн Мартин Бомле тайлбарлав. Хориг хүчин төгөлдөр болсноор сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл урагшилж, Швейцарьт оруулах

гаднын хөрөнгө оруулалт өснө хэмээн тэрбээр үзэж байна.

“Германьхтай харьцуулахад манай бодлого арай либерал. Гэхдээ л шинээр цөмийн цахилгаан станц байгуулах боломж бүрмөсөн хаагдлаа” хэмээн судалгааны Avenir Suisse байгууллагын ахлах шинжээч Патрик Дюммлер өгүүлэв.

Аюулгүй байдлын стандарт чангарсаар байгаатай уялдан цөмийн цахилгаан станц байгуулах нь өртөг зардлын хувьд хэт үнэтэй болж хувирсан талаар Берн тайлбарлаж байна. Их Британид Хинкли Пойнтын АЦС-ыг байгуулах 18 тэрбум фунт стерлингийн зардлыг үндсэндээ төрийн зардлаар санхүүжүүлэх гэж байгааг Берн

эш татсан юм.

Харин сөрөг хүчнийхэн Засгийн газрыг хэт зардалтай, эрчим хүчний аюулгүй байдалд занал учруулсан төлөвлөгөө боловсрууллаа хэмээн шүүмжилж байна. Швейцарийн шинэ төлөвлөгөөнд автомашинаас төдийгүй нийт эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг цаашид үргэлжлүүлэн бууруулах заалт оржээ.

Салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий эрчим хүчний хэрэглээ нь Швейцарийн үндэсний ашиг сонирхол байх юм. Мөн эрчим хүчний үр ашигтай барилга байгууламж байгуулах ажилд санхүүгийн туслалцаа дэмжлэг үзүүлэх явдал цаашид өргөжнө.

ХБНГУ, Дани, Итали зэрэг Европын бусад улс ч дээрхтэй төстэй эрчим хүчний бодлогын шинэчлэл өрнүүлж байгаа. “Гэхдээ улс болгон нийт иргэдийнхээ саналыг сонсох бодлого баримтлаагүй болохоор манай санал хураалт арай өвөрмөц” хэмээн Гэгээн Галений их сургуулийн сэргээгдэх эрчим хүчний мэргэжилтэн Рольф Вюстенхаген тайлбарлав.

Швейцарь орон цөмийн эрчим хүчнээ бүрмөсөн татгалзах нь одоогийн АЦС-уудынх нь хөрөнгө оруулалт зах зээл дээр хэр хурдан нөхөгдөхөөс шалтгаална. Юутай ч 2030 оноос цааш байж таарна хэмээн шинжээчид өгүүлж байна.

FT

FT



Эдийн засгийн албан тушаалуудын зэрэгцээ шинэ Ерөнхийлөгч НҮБ-д ажиллаж байсан туршлагатай, ахмад дипломатч Кан Киун Хвад Гадаад хэргийн яамыг хариуцуулжээ.

корпорациудад хяналт тавих үүрэг хүлээлгэв. Уг тушаалд нэр хүндтэй Кореа их сургуулийн профессор Жан Ха Суныг томилсон нь том корпорациудын дунд болгоомжлол үүсгэж болзошгүй юм. Ноён Мун тус улсын бизнес орчинд агаар оруулж, чазбол хэмээх гэр бүлийн корпорациудыг өөрчлөхөөр төлөвлөж буй. Тусгай хүчний байлдагч асан, хүний эрхийн хуульч Ким Сан Жо хэмээх “чаэболын ангууч” гэж алдаршсан корпорацийн удирдлагтай тэмцэгч хүнийг трастын эсрэг зохицуулагчийн ажилд авсан байна. Тэрбээр нэг уулзалт дээр Samsung Electronics-ийн ерөнхий захирал улс төрийн хуульч бус хандив өгч байгааг шүүмжлэн үг хэлсний учир тэндээс хөөгдөж байжээ. Өмнөд Солонгосын дөрвөн том чазбол буюу Samsung, Hyundai, SK, LG гэр бүлийн компаниуд тус улсын хөрөнгийн зах зээлийн тэн

сургуулийн захирал Ким Ву Чан “Корпорацийн удирдлагыг шинэчлэх олон хэмжүүр бий. Үүний нэг нь хувьцаа эзэмшигчдийн эрх хэмжээг өргөтгөж, гаднаас захируудыг томилсноор дотоодын захирал, менежер, гэр бүлийн гишүүдийг хянах явдал юм. Корпорацийн удирдлагыг шинэчлэх нь Солонгосын компаниудад туслахын хамт эдийн засгийн өсөлт, инновацид саад хийхгүй байх ёстой” хэмээн өгүүлсэн юм. Эдийн засгийн албан тушаалуудын зэрэгцээ шинэ Ерөнхийлөгч НҮБ-д ажиллаж байсан туршлагатай, ахмад дипломатч Кан Киун Хвад Гадаад хэргийн яамыг хариуцуулжээ. Сөүл Хойд Солонгосын өдөөн хатгалгыг зогсоход гүйцэтгэх үүргээ нэмэгдүүлэхийг эрмэлзэж буй үед гадаад бодлогын тэргүүн нь маш чухал албан тушаал юм. Гуравдугаар сард хуучин Ерөнхийлөгч Пак Гын Хэд улг итгэх асуудлаар санал

Ерөнхийлөгч Мун танхимаа томиллоо

Брайан Харрис

Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгч ням гарагаас танхимынхаа суудлуудыг хуваарилж эхэлсний анхных нь Сангийн болон Гадаад хэргийн сайд нар байлаа. Түүнд эдийн засаг, аюулгүй байдлын хүнд сорилтууд дундуур улс орноо авч явах хариуцлагатай үүрэг ногдоод байгаа билээ.

Туршлагатай улс төр, нийгмийн зүтгэлтэй Ким Дон Ёныг Сангийн сайдаар томилсон нь бүс нутагтаа дөрөв дэх эдийн засгийн гүнзгий хямралыг харуулж байна гэж ажиглагчид тэмдэглэв. Нэг Өмнөд Солонгос хөгжлийн үлгэр жишээ болж байсан хэдий ч өнөөдөр өсөлт удааширч, ажилгүйдэл нэмэгдэхийн сацуу өрхийн зээл 2016 оны эцэст нэг

тэрбум ам.долларт хүрч, дарамт үүсгээд байна.

Ноён Мун сонгуулийн өмнөх сурталчилгаагаа эдийн засгийн шинэчлэлийн уриан дор явуулсан бөгөөд улсын салбарт 800 мянган ажлын байр бий болгох, 10 хувьд хүрээд буй залуусын ажилгүйдлийг шийдэх амлалт авсан. Өмнөд Солонгосын удирдагч хэлэхдээ

ноён Кимийг сонгосон нь тэрбээр оюутан цагтаа Сөүлд ажил хийж амьдралаа босгосны дээр “хямралыг давж туулах болон өөрчлөлт хийх чадвар”-т тулгуурласныг онцолжээ. Түүнчлэн Ерөнхийлөгчийн захиргааны бодлогын тэргүүн хэмээх шинэ албан тушаал бий болгож, урт хугацааны эдийн засгийн бодлогыг тодорхойлох,

хагасыг эзэлдэг агаад улс төрийн зорилгоор хандив өргөдөг хэмээн олонтаа шүүмжлэгдэж байв. Ерөнхийлөгч Мун хэт томорсон корпорациудыг шинэчлэх төлөвлөгөөгөө танилцуулж амжаагүй байгаа ч тэдгээрийн захирлуудыг авлигын хэргээс чөлөөлдөг буруу практикийг зогсоохоо мэдэгдсэн билээ.

Кореа их сургуулийн бизнес

хурааж, огцруулснаас хойш Өмнөд Солонгосын Умардын цөмийн хөтөлбөрийн талаарх хэлэлцүүлгээс хөндийрөөд байсан билээ. Уг байдлыг шинэ засаг захиргаа засах ёстой болж байна. Сангийн ба Гадаад хэргийн сайд нарыг томилох асуудлыг Үндэсний ассамблейгаар хэлэлцэх авч батлуулах шаардлагагүй аж.



Трампын анхны гадаад айлчлал



Саймон Керр

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп бямба гарагийн өглөө Рияд хотод буухад Саудын Арабын Ван өөрийн биеэр угтан авлаа. Обамагийн засаглалын үед хүйтэрсэн харилцааг сайжруулахын хамт 350 тэрбум ам.долларын өртөгтэй гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурахыг албаны хүмүүс мэдээлжээ. Үүний дотор Саудын Араб болон булангийн орнуудад Ираныг эсэргүүцэх, терроризмтэй тэмцэхэд зориулсан 110 тэрбумын зэвсэглэл нийлүүлэх гэрээ нь АНУ-ын ачааллыг хөнгөлөх зорилготой гэж Цагаан ордны төлөөлөгч мэдээлэв. Гэрээ хэлцлийн өртгөөс үзэхэд Саудын Арабын талаас АНУ-ын дэд бүтэцэд хөрөнгө оруулж, Америк хариуд нь зэвсэг нийлүүлэх төлөв харагдаж байна. Саудын Араб мөн нефтийн үнийн уналтаас суларсан эдийн засгаа сэргээн төрөлжүүлэхийг эрмэлзэж байгаа. Саудын Араб шинээр эхэлж буй бизнесийн харилцааг Арабын ертөнц дэх Ираны нөлөөг хязгаарлах улс төрийн зорилгод

нийцүүлэхийг хичээж байгаа аж. Ноён Трамп бямба гарагт Саудын удирдагчидтай улс төр, эдийн засгийн хэлэлцээ хийсний дараа ням гарагт исламын 50 орны удирдагчдын өмнө үг хэлэхээр төлөвлөжээ. Ерөнхийлөгчтэй хамт ирсэн хатагтай Мелани Трамп исламын ёс жаягийн дагуу толгойдоо алчуур зүүхгүй ч алтан чимэглэл зүүж, даруухан хувцасласан байв. Обамаг энд айлчлахад Саудын Ван угтахаар ирээгүй бол Трампыг биеэр хүлээн авсан нь хэвлэл мэдээллийн анхаарлын гадна үлдсэнгүй.

Саудын Арабын Эрчим хүчний сайд Халид Фалих “Засгийн газар арагш сууж, эдийн засгийг хөгтөх үүргийг хувийн салбарт өгч байгаа. Энд эрсдэл гарах нь мэдээж. Гэхдээ бид үүнээс сэргэмжлэхийн тулд та бүхэнтэй хамтран ажиллана” гэж мэдэгдэв. Саудын Agamco хэмээх улсын нефтийн компани 50 тэрбум ам.долларын өртөгтэй гэрээ хамтарсан үйлдвэр Саудын Арабт нефтийн цамхаг, тоног төхөөрөмж

үйлдвэрлэх аж. Agamco Америк дахь салбар Motiva компанидаа 12 тэрбум ам.долларын хөрөнгө оруулж, 2023 онд 18 тэрбумын нэмэхээр төлөвлөж байна. Эдгээрийн үр дүнд 12000 ажлын байр бий болно.

Америкийн зургаан компани Саудын нефтийн аварга компанид бүтээгдэхүүнээ нийлүүлэх харилцан ойлголцлын санамжид гарын үсэг зурлаа. Agamco түүнчлэн Америкийн General Electric-тэй хамтран нефть олборлолтыг цахимжуулах төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулав. Оны эхээр Саудын угсаа залгамжлах жонон Мохаммед би Салман Вашингтонд айлчлах үеэр Цагаан ордон Саудын Арабын зүгээс оруулах хөрөнгө 200 тэрбум ам.долларт хүрэхийг мэдээлж байсан. Батлан хамгаалах салбарт Lockheed Martin компани Саудын Арабт 150 Blackhawk нисдэг тэрэг угсрах 65 тэрбум ам.долларын өртөгтэй үйлдвэр барих бөгөөд 450 ажлын байр бий болгоно. Бусад компани ч бас батлан

хамгаалахын захиалгыг орон нутагт нь гүйцэтгэх хэлцэл хийжээ.

Дэлхийд батлан хамгаалахын зардлаар гуравт бичигддэг Саудын Араб улс орондоо зэвсгийн үйлдвэрлэл хөгжүүлэхэд ихээхэн анхаарч буй. Тус улс 2030 он гэхэд батлан хамгаалах зардлынхаа 50 хувийг дотоодын үйлдвэрүүдэд төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Саудын улсын Хөрөнгө оруулалтын сан АНУ-ын дэд бүтцийн Blackstone санд 20 тэрбум ам.доллар оруулах гэрээ байгуулсан байна. Blackstone голдуу АНУ-д 100 тэрбумыг дэд бүтэцэд оруулахаар төлөвлөж буйгаа мэдэгдсэн байна. Үүний зэрэгцээ Саудын Худалдаа, хөрөнгө оруулалтын сайд Абдулла Кассаби Америкийн 19 компанид үйл ажиллагааны зөвшөөрөл олгохоо амлав. Бямба гарагийн үдэш ван Салман болон Ерөнхийлөгч Трамп нартай зоог барихад Саудын Араб, АНУ-ын 70 компанийн захирал байлцсан байна.

Японы эзэн хааныг залгамжлагч цөөрсөөр

Робин Хардинг

Гүнж Мако энгийн хүнтэй сүй тавьсан нь Японы эзэн хааны гэр бүлд үе залгамжлах болон хүйсийн асуудлыг ил болголоо. Гүнжийн их сургуулийн найз гэгдэх хуульч залуу нийгэмд хөгжөөнтэй яриа үүсгэсэн хэдий ч эзэн хааны гэр бүлийн гишүүн цөөрөх зовнил төрүүлэв. Энгийн хүнтэй гэрлэсэн гүнж хуулийн дагуу хааны гэр бүлийн гишүүнээс хасагдах ёстой. 25 настай Мако шинэхан хуульч Кей Комуротой гэрлэвэл эзэн хааны гэр бүлийн гишүүний тоо 19 байснаас 18 болж цөөрөх гэнэ.

Баасан гарагт 83 настай Акихитогийн хаан ширээнээсээ буух хүсэлтийг хэлэлцсэн сайд нарын танхим зөвшөөрсөн шийдвэр гаргасан нь гүнжийн сүй тавьсантай нийлээд олны дунд маргаан дэгдээж орхилоо. Эмэгтэй хүнээр залгамжлуулах асуудал яригдаагүй хаант засаглалын бүтцийг хэрхэн хадгалах талаар яриа өрнөж байна. Түүнчлэн нийгэм дэх эмэгтэйчүүдийн тэгш бус байдал, Ерөнхий сайд Шинзо Абэгийн санаачилсан “womemomics”-ийн бодлого, Японы хүн амын насжилт нэмэгдэж, төрөлт буурсан зэрэг олон эхтэй сэдэв уг маргааныг өрдөх шалтгаан болов. Гэр бүлийн гишүүний тоо цөөрөхөд үлдсэн хүмүүсийн үүрэг нэмэгдэнэ. Ийм хандлага үргэлжилбэл ханхүү Хисахито ганцаар үлдэж байна. Гэвч тэр “Эзэн хааны гэр бүлийн бүх хариуцлагыг ганцаар үүрч чадахгүй” хэмээн өгүүлжээ. Одоогийн эзэн хаан шийдвэр ёсоор 2018 оны эцэст суудлаа өөрийн хүү, ханхүү Нарухитод шилжүүлбэл тэрбээр эзэн хаан болно. Нарухитогийн ганц охин, гүнж Аико одоо 15 настай. Иймээс үе залгамжлах дараагийн үе нь Нарухитогийн дүү, ханхүү Акихито болон түүний ганц хүү 10 настай Хисахито нар юм. Зарим шинжээч эзэн хаан Акихито суудлаа өгсний дараа хаан ширээг эмэгтэй хүнд үе залгамжлуулах хөдөлгөөн өрнөх байх гэж найдаж байгаа аж.

Мөн үеэр ноён Абэгийн томилсон мэргэжилтний зөвлөл эзэн хааны гэр бүлийн тоо цөөрч

байгаа талаар хойшлуулалгүй арга хэмжээ авах ёстойг анхааруулсан боловч эмэгтэй залгамжлагчийн талаар үг дуугараагүй байна. Кобегийн их сургуулийн профессор Хидеяа Каваниши “Эрэгтэй залгамжлагчийг дэмжигчид эцсээ хүртэл тэмцэж, асуудлыг аль болох хойшлуулахыг эрмэлзэж байгаа. Гэвч өнөөгийн нөхцөл байдал сонголт өгөхгүй байгаа тул танхимд томоохон бэрхшээл үүслээ” гэв. Японы ард иргэдийн олонх нь эмэгтэй залгамжлагчийн үзэл санааг дэмжиж байгаа боловч идэвхгүй байгаа тул Абэд шийдвэр гаргах шахалт болж чадахгүй байгааг Токиогийн их сургуулийн профессор Сота Кимура ярилаа.

Энэ нь нэг талаар гүнж Аико олны нүднээс далд, өөрийн болон ээж Масако гүнжийн эрүүл мэндийн байдалд анхааран амьдардгаас болсон цааш нь “Хамгийн муу тохиолдол буюу ханхүү Хасихито үе залгамжлах боломжгүй болбол сэрээх дохио хангинаж магадгүй. Маргаан хэлэлцүүлэг урагш ахиуцгүй байгаа тул одоогийн эзэн хаан болон түүний гэр бүл хүлээгдсэн маягтай байгаа” хэмээн өгүүллээ.

Хааны гэр бүлийнхний тоог цөөрөхөөс сэргийлэх хамгийн энгийн арга бол Мако гүнжийг гэрлэсний дараа эзэн хааны бүлд үлдээх явдал юм. Гэвч хагуу хуучинсаг үзэлтнүүд эрс эсэргүүцэж буй. Үндсэрхэг үзэлт Шанкей сонинд “Гүнжүүд болон тэднээс гаралтай хөвгүүдэд хүртэл хаан ширээг залгамжлахад ихээхэн саад учирч болзошгүй” хэмээн бичсэн байна. Хуучинсаг үзлийг баримтлагчдын санаагаар бол эзэн хааны гэр бүлийн эртний салаа мөчрөөс хан хөвгүүдийг тодруулан хааны гэр бүлийн гишүүн болгох ёстой аж. Гэвч ноён Куно хэлэхдээ иймэрхүү хан хөвгүүд эзэн хааны уламжлалаар хүмүүжээгүй тул гар даллахаас цаашгүй байх биз гэжээ. Тэрбээр “Олон нийт үүнийг хүлээн авах уу. Би хувьдаа бодитой бус санал гэж бодож байна” хэмээн шүүмжиллээ.



Эдийн засаг

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгө оруулалтыг хялбар босгох гарц

Давхар бүртгэлийн системийг Монголд нутагшуулна



С.Батсайхан / ЗГМФ

Ингэснээр дотоодын хөрөнгө оруулагчдад дээр дурдсан 11 компанийн үнэт цаасыг санал болгох шинэ нөхцөл бүрдэх хүлээлт үүсээд байна.

Дотоодын компаниуд гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгүүлснээр хөрөнгө оруулалтыг татах, гадаад харилцагчтай болох юм. Манай улсад давхар бүртгэлийн эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд энэ нь Үнэт цаасны тухай хуульд тусгалаа олсон байдаг. Гэхдээ шинээр дагалдах дүрэм, журмыг гаргах шаардлагатай байгааг Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай хэлж байсан удаатай. Давхар бүртгэлийн системийг дотоодын хөрөнгийн зах зээлд нутагшуулахад Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа, холбоо чухал болохыг Эдийн засагч Ж.Дэлгэрсайхан тодотголоо. Давхар бүртгэлийн системийг эхлүүлэх талаар Монголын хөрөнгийн бирж өмнө нь Казахстаны хөрөнгийн биржтэй холбоо, харилцаа тогтоож байсан.

Уг систем санхүүгийн зах зээлийн таван хувийг бүрдүүлж буй хөрөнгийн зах зээлд байраа олсноор манай улсын хөрөнгийн бирж олон улсын хөрөнгийн зах

зээлийн холбогч гүүр нь байх өөдрөг төсөөлөл бий. Тэрчлэн санхүүгийн бусад төвтэй өрсөлдөхүйц түвшинд ирэх найдвар байгаа. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд давхар бүртгэлийн системийн үүрэг, оролцоо чухал болохыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн тодотгосон удаатай. Бодлогын түвшинд давхар бүртгэлийн системд анхаарал хандуулж, мэргэжлийн байгууллагуудын анхааралд энэ систем ороод байна. Энэ сарын

эхээр болсон “Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа болон давхар бүртгэл” семинар үүнийг илүү тодотгож байсан юм.

Компаниуд давхар бүртгэл хийж, гадаадын зах зээлд гарах, гадаадын компаниуд манай хөрөнгийн зах зээлд орж ирэх боломж, нөхцөлийг судалж эхэлсэн байна. Манай улсын хувьд хөрөнгийн зах зээл хөгжих газар зүйн таатай бус. Учир нь дэлхийн тэргүүлэгч хоёр том зах зээлийн дунд

Давхар бүртгэлийн эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Үнэт цаасны тухай хуульд тусгалаа олсон

байрладаг нь санхүүгийн зах зээлд давуу тал болж байна. БНХАУ болон ОХУ-ыг холбох, тухайн орнуудын хөрөнгийн зах

зээлд нэвтрэх түлхүүр улс болох нөөц, боломжтой юм. Түүнээс гадна хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор татварын таатай орчныг бүрдүүлэх нь илүү үр дүнтэй зарим эдийн засагч онцолж буй. Манай улсын хөрөнгийн биржид одоогоор 219 компани бүртгэлтэй. Эдгээр компаниас 44 хувь нь өнгөрсөн онд ашигтай ажилласан байдаг. Давхар бүртгэлийн системийг эхлүүлснээр дотоодын компаниудын ашиг, орлогын өгөөж нэмэгдэх боломжтой аж. [ЗГМ]

СТАТИСТИК

Өрхийн дундаж орлого 2.6 хувиар өсчээ

Ж.Жаргалмаа
Шинжээч

Азийн хэмжээнд Монгол Улсын харилцаа холбоо дундаж түвшинд байгаа олон улсын төлөөлөл хэллээ. "Big data" буюу уламжлалт дата боловсруулах системийг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. 2020 он гэхэд дэлхийн хүн бүр, секунд тутамд 1.7 мегабайт дата үүсгэнээр, дижитал орчны нийт дата 44 их наяд гигабайт болж нэмэгдэх хандлагатай байгаа аж. "Big data"-ийн нэг чухал үзүүлэлт нь иргэн бүрт хамааралтай байх өрхийн судалгаа юм. Үүний дагуу өрхийн судалгааг шинэ аргачлалаар анх удаа боловсруулжээ. Энэ оны эхний улиралд нэг өрхийн сарын дундаж орлого 2.6 хувиар өсөж, зарлага мөн 2.6 хувиар буурсан

байна. Гэсэн хэдий ч зарлага нь орлогоосоо 7.3 хувиар илүү байгаа юм. Цалин, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн орлого өссөн бол хүнсний бус барааны үнэ буурснаар зарлага багассан байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2017 оны эхний улиралд хүнсний бус барааны төрлөөс шуудангийн үйлчилгээ 1.2 хувь, орон сууцны урсгал зардалын үнэ 0.5 хувиар буурчээ. Мөн дөрөвдүгээр сарын хэрэглээний үүнийн индекс өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар, 2016 оны эцэстэй харьцуулахад 5.2 хувиар, өмнөх сартай харьцуулахад 1.5 хувиар тус тус өссөн байна. Өрхүүдийн орлогыг ялгахад 300 мянгаас доош орлоготой өрх 13.4, хоёр сая төгрөгөөс дээш орлоготой өрх 43.4 хувийг эзэлжээ.

БИЗНЕС

"Mongolia Growth Group"-ийн орлого 18 хувиар буурав

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Mongolia Growth Group" хувьцаа эзэмшигчдийн хурлаа ирэх зургадугаар сарын 14-нд хийхээр товлолоо. Үүний зэрэгцээ тус компани энэ оны эхний

ХУДАЛДАА

Япон улсын экспорт 7.5 хувиар өслөө

Япон улсын экспорт дөрөвдүгээр сард жилийн өмнөхөөс 7.5 хувиар өслөө. Ингэснээр тус улсын экспорт таван сар дараалан нэмэгдсэн төдийгүй энэ нь сүүлийн 10 жилийн хамгийн удаан үргэлжилж буй өсөлт болж байна. Үүнээс гадна Японы импорт дөрөвдүгээр сард 15.1 хувиар тэлснээр худалдааны

улирлын санхүүгийн тайлангаа танилцуулсан байна. Тайлант хугацаанд тус компанийн нийт орлого жилийн өмнөхөөс 18 хувиар буурч, 401 мянган канад доллар болжээ. Нийт орлогынх нь 96 хувийг түрээсийн орлого бүрдүүлсэн байна. Харин "Mongolia Growth Group"-ийн цэвэр

алдагдал 643.1 мянган канад доллар болсон нь 2016 оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин нэмэгджээ. Тайлант хугацаанд дээрх компанийн богино хугацааны хөрөнгө оруулалтаас 467.5 мянган канад долларын гарз буюу алдагдал хүлэсэн нь ийнхүү цэвэр алдагдал ихсэхэд нөлөөлсөн байна.

Олон улсын хэмжээнд ялангуяа БНХАУ-ын эрэлт нэмэгдэж байгаа нь Японы экспортод эерэг нөлөө үзүүлж байгаа аж. Түүнчлэн хэрэв экспортын үзүүлэлт сайн хэвээр байвал Япон улсын дотоодын нийт бүтээгдэхүүн энэ онд дахин 0.5 хувиар өснө гэж шинжээчид таамаглажээ.

ЗГМ ТОВЧХОН

» БАНК, САНХҮҮ

1.1

Их наяд төгрөг. Монголбанкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 1.1 их наяд төгрөгт хүрэв.

» УУЛ УУРХАЙ

165

Тусгай зөвшөөрөл. Хэнтий аймгийн хэмжээнд уул уурхайн ашиглалтын 107, хайгуулын 165 лиценз буюу тусгай зөвшөөрөл хүчинтэй байна.

» САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

94.7

Хувь. Улсын хэмжээнд банк бус санхүүгийн нийт 529 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүний 94.7 хувь нь Санхүүгийн зохицуулах хороонд тайлангаа ирүүлжээ.

» ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

"Аймгуудын өрсөлдөх чадварын 2016 оны тайлан"-д Дархан-Уул 21 аймгаас гуравдугаар байрт эрэмбэлэгджээ. Энэхүү тайланг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс тав дахь жилдээ бэлтгэн гаргаад буй юм. Ингэхдээ аймгуудын өрсөлдөх чадварыг 180 үзүүлэлтээр хэмжэжээ.

» СТАТИСТИК

33

Хувь. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 33 хувь нь Улаанбаатарт байна.

» ТӨСӨВ

13

Хувь. Улсын нэгдсэн төсвийн орлогын 13 хувийг татварын бус орлого эзэлж байна.

» ДЭД БҮТЭЦ

"МИАТ" компани Хонконгийн агаарын тээврийн "Cathay Pacific" компанитай хийсэн аяллын дугаар хамтран эзэмших гэрээний дагуу долдугаар сараас эхлэн нийт гурван улсын зургаан хот руу хамтарсан нислэг үйлдэхээр төлөвлөж байгааг мэдээллээ.

» ТЭЭВЭР

875.6

Тонн ачаа. Агаарын тээврээр энэ оны эхний дөрвөн сард 875.6 тонн ачаа, давхардсан тоогоор 202.5 мянган хүн тээвэрлэжээ. Тээвэрлэсэн ачааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувиар буурсан байна.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ

Орлогын бонд-Revenue bond-Орон нутгийн засаг захиргаанаас усан хангамжийн объект, зам, онгоцны буудал, боомт, цахилгаан станц барих зорилгоор гаргадаг бонд. Тус бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг татварын орлогоор бус, харин бондоор санхүүжүүлсэн төслөөс орж ирэх орлогоор барагдуулна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2417.20
Евро	2700.37
Япон иен	21.72
ОХУ рубль	42.75
БНХАУ юань	350.75
БНСУ вон	2.16

Шилдэг САНАА

Bloomberg
TV Mongolia

"Шилдэг санаа" нэвтрүүлгээр энэ хөгжлийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг. Энэ удаа Хятадын уран бүтээлч Шү Бингтэй танилцах болно. Шү Бинг оюунлаг, эрдэм боловсролтой нэгэн хэдий ч түүний дотор яруу найрагчийн зүрх цохилж байдаг. Тэр ямар ч эргэлзээгүй өөрийнхөө үеийн Хятадын хамгийн чухал уран бүтээлчдийн нэг мөн.

Пүрэв гараг /2017.05.25/

20:30

11:30 Баасан гараг
09:30 Бямба гараг
18:00 Ням гараг

Эдийн засаг

Уул уурхай

“Оюутолгой”-н орлого 5.7 хувиар нэмэгдэж, 237.5 сая ам.долларт хүрэв

“Оюутолгой” компанийн орлого энэ оны эхний улиралд жилийн өмнөхөөс 5.7 хувиар нэмэгдэж, 237.5 сая ам.долларт хүрчээ. Орлого өсөх болсон нь зэсийн борлуулалтын дундаж ханш өндөр байснаас гадна бор-

луулсан баяжмал дахь зэсийн хэмжээ их байсантай холбоотой гэж “Оюутолгой” компаниас мэдээллээ. Тус компани нэг-дүгээр улиралд гүний уурхайн өргөтгөлийн ажилд 136.4 сая ам.доллар зарцуулсан байна.

Мөн хэд хэдэн томоохон гэрээ байгуулсны нэг нь налуу нэвтрэлтийн материал зөөвөрлөх системийн гэрээ аж. Тайлант хугацаанд гүний уурхайн хөндлөн нэвтрэлт, II, V босоо амны нэвтрэлт, туслах


дэд бүтцийн болон налуу ам, үйлчилгээний порталын ажлыг гүйцэтгэж байна.

Мөн “Оюутолгой”-н баяжуулах үйлдвэрт эхний улиралд өдөрт дунджаар 112.1 мянган тонн хүдэр боловсруулсан нь

өмнөх улирлынхаас 5.1 хувиар нэмэгдсэн байна. “Оюутолгой”-н гүйцэтгэх захирал Армандо Торрес “Энэ оны эхний улиралд “Оюутолгой” амжилттай ажиллалаа. Үйл ажиллагааны гол хэсгүүдэд дээд амжилт тогтоон ажиллаж, гүний уурхайн төслөө ахицтай урагшлуулсан” гэв. “Оюутолгой”-н ус дахин

ашиглалтын түвшин 88.7 хувьтай байна. Компанийн нийт ажиллах хүчний 93 хувийг монгол ажилчид бүрдүүлж байгаа аж. Энэ оны эхний улиралд “Оюутолгой” дотоодын ханган нийлүүлэлт, үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж, 75 сая ам.долларыг зарцуулсан байна. [ЗГМ]

Хөрөнгийн биржийн индекс 0.4 хувиар өсөв



Монголын хөрөнгийн бирж даваа гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй 26 хувьцаат компанийн нийт 104759 ширхэг хувьцаа арилжжээ. Хөрөнгийн биржийн индекс энэ өдөр 845.01 нэгж болж 0.4 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн арилжаагаар 18528 ширхэг үнэт цаас арилжлаа. [ЗГМ]

Ханшийн өөрчлөлтийн хувьд 21 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орсон байна. Үүнээс “Зоос гоёл” компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 14.97 хувиар өссөн бол “Монгол алт”-ынх 12.65 хувиар уналаа. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 18528 ширхэг үнэт цаас арилжлаа. [ЗГМ]

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

MSE ALL

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	65.2	▲ +3.08%	5/22/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.039	▼ -5.41%	5/22/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	21.375	▼ -0.57%	5/22/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.019	▼ -5.26%	5/22/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	5/22/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.07	▲ -0.32%	5/22/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.72	▼ -7.51%	5/22/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.395	▲ +25.4%	5/22/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▲ +2.44%	5/22/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.62	▼ -12.73%	5/22/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1256.27	▼ +0.03%	5/22/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	940.5	▲ +0.03%	5/22/2017
МӨНГӨ	SIA	унци	16.96	▼ +0.98%	5/22/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	258.1	▼ -0.02%	5/22/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	61.91	▲ +0.65%	5/22/2017
WTI ТОС	CLA	баррель	50.7	▲ +0.74%	5/22/2017
БРЕНТ	COA	баррель	54	▲ +0.73%	5/22/2017
БЕНЗИН	XBA		165.98	▲ +0.45%	5/22/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.31	▲ +1.66%	5/22/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	5/22/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	74.5	▲ +0.54%	5/22/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	16.26	▲ -0.73%	5/22/2017
БУДАА	RRA	центнер	10.83	▲ -0.09%	5/22/2017
БУУДАЙ	WA	бушель	438.25	▲ +0.69%	5/22/2017
КАКАО	CCA	тонн	2044	▲ +0.79%	5/22/2017
КОФЕ	KCA	фунт	132.35	▲ +0.19%	5/22/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	328.16	▲ 2.55%	5/22/2017
ГОВЬ ХК	GOV	13910	▲ 2.35%	5/22/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	10980	▼ -0.18%	5/22/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20500	◄ 0%	5/22/2017
СҮҮ ХК	SUU	127	▼ -1.02%	5/22/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	21500	◄ 0%	5/22/2017
БИ ДИ СЕК ХК	BDS	1200	◄ 0%	5/22/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	124	▼ -0.80%	5/22/2017
ХӨХ ГАН ХК	HGN	58.01	▲ 5.47%	5/22/2017
ЖЕНКО ТҮР БҮРЯ ХК	JTB	54.56	▲ 2.96%	5/22/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	540.32	▼ -1.76%	5/22/2017
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	390	▼ -2.50%	5/22/2017
МАТЕРИАЛ ИМПЕКС ХК	MIE	8000	▼ -1.23%	5/22/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	379.98	▲ 2.73%	5/22/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2250	◄ 0%	5/22/2017
УИД ХК	UID	520	▼ -3.70%	5/22/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6083.703	+28.57	▲ +0.47%	5/22/2017
DAX INDEX	DAX	12587.23	-51.46	▼ -0.41%	5/22/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15458.46	+181.26	▲ +1.19%	5/22/2017
S&P/ASX 200	AS51	5771.205	+43.8	▲ +0.76%	5/22/2017
S&P 500	INX	2381.73	+16.01	▲ +0.68%	5/22/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3075.676	-14.96	▼ -0.48%	5/22/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20804.84	+141.82	▲ +0.69%	5/22/2017
TOP 20	MSETOP	12784.2	+99.76	▲ +0.79%	5/22/2017
FTSE 100	UKX	7492.96	+22.25	▲ +0.3%	5/22/2017
HANG SENG	HSI	25391.34	+216.47	▲ +0.86%	5/22/2017
NIKKEI 225	NKY	19678.28	+87.52	▲ +0.45%	5/22/2017

ДЭЛХИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАРДАЛ

ХОВОРДСОН АН, АМЬТДЫГ АВРАХАД

\$ 75 ТЭРБУМ

ЖИЛ БҮР

ХӨРСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	ТАЛБАЙН САЙЖРУУЛАЛТ	УДИРДАГАЙН ЗАРДАЛ	ТӨЛӨВӨЛТ, ЗАГВАР	НӨХӨН СЭРГЭЭЛТ	ОРЧНЫ ТОХИРУУЛГА	ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ	ЭМЧИЛГЭЭ, ОНОШИЛГОО	ГЭНЭТИЙН ЗАРДАЛ
\$50.2 ТЭРБУМ	\$1.5 ТЭРБУМ	\$3.7 ТЭРБУМ	\$1.0 ТЭРБУМ	\$5.3 ТЭРБУМ	\$7.0 САЯ	\$7.1 ТЭРБУМ	\$4.4 ТЭРБУМ	\$7.0 САЯ	\$1.4 ТЭРБУМ

ДЭЛХИЙД ИЛҮҮ ОЛОН ТЭРБУМТАН ХЭРЭГТЭЙ